## ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
## 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 05-ний өдөр | Улаанбаатар хот

| **д/д** | | **Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Зорилтот түвшин** | **Гүйцэтгэл** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 1. *ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИД СУУРИГСАН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОНО.*** | | | | | | | | |
| ***НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ, ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 33 дүгээр заалт, ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН ДҮРЭМ 4.1,4.2,4.3.1, 4.3.2.*** | | | | | | | | |
| **1** | | **Зорилт 1: Дэд бүтцийн хэвийн ажиллагаар хангах;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **7** | **Гүйцэтгэл** | |
| 1 | **1.1.1** | UPS төхөөрөмжийг шинээр суурилуулах, холболтуудыг хийж гүйцэтгэх | Гадны зээл тусламж | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Шинээр UPS төхөөрөмжийн суурилуулалтыг хийж ашиглалтад оруулан цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаар хангаж ажилласан байх. | 0 | 1 | • Тендерийн баримт бичигт шаардлагатай техникийн тодорхойлолт болон бусад хавсралт баримт бичгийг боловсруулж, төсөл хэрэгжүүлэгч талд хүлээлгэн өгсөн;<br>• UPS төхөөрөмж болон баттерейн захиалга хийгдсэн. Гүйцэтгэгч байгууллагатай хамтран UPS төхөөрөмж болон баттерей байрлах техникийн өрөөний зохион байгуулалтын шийдлийг боловсруулан танилцуулж, батлуулсан. Уг ажлын гэрээний хугацаа 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдөр дуусаж байгаа бөгөөд энэхүү ажил үйлчилгээтэй холбоотойгоор тус төвийн зүгээс шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан. (2026 оны 1 дүгээр сарын 20-нд үйлдвэрлэгдэж, 2 дугаар сарын 20-нд угсралт суурилуулалтын ажил хийгдэж эхлэх талаар гүйцэтгэгч талаас мэдээллийг ирүүлсэн.) | 100% |
| 2 | **1.1.2** | Төвийн дизель генераторын байгууламжийг шинэчлэн, сайжруулах | Гадны зээл тусламж | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Дизель генераторын байгууламжийг шинэчлэн сайжруулж нөөц цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаар хангаж ажилласан байх. | 0 | 1 | • Генераторын захиалга хийгдсэн. Генератор суурилуулах ажлын зургийг гүйцэтгэгч байгууллагатай зөвшилцөж батлуулсан. Уг ажлын гэрээний хугацаа 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдөр дуусаж байгаа бөгөөд энэхүү ажил үйлчилгээтэй холбоотойгоор тус төвийн зүгээс шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан. (2026 оны 1 дүгээр сарын 20-нд үйлдвэрлэгдэж, 2 дугаар сарын 20-нд угсралт суурилуулалтын ажил хийгдэж эхлэх талаар гүйцэтгэгч талаас мэдээллийг ирүүлсэн.) | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **1.1.3** | UPS өрөөний агаарын хөргөлт чийгшил тогтворжуулах систем, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх | Гадны зээл тусламж | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Шинээр суурилагдах UPS байгууламжийн хөргөлтийн төхөөрөмжийг суурилуулж агаарын хөргөлт чийгшил тогтворжуулах систем, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллах байдлыг нэмэгдүүлсэн байх. | 0 | 1 | • Хөргөлтийн төхөөрөмжийн захиалга хийгдсэн. Уг ажлын гэрээний хугацаа 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдөр дуусаж байгаа бөгөөд энэхүү ажил үйлчилгээтэй холбоотойгоор тус төвийн зүгээс шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан. (2026 оны 1 дүгээр сарын 20-нд үйлдвэрлэгдэж, 2 дугаар сарын 20-нд угсралт суурилуулалтын ажил хийгдэж эхлэх талаар гүйцэтгэгч талаас мэдээллийг ирүүлсэн.) | 100% |
| 4 | **1.1.4** | Дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах | Дотоод нөөц | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Төвийн дэд бүтцэд байршин ажиллаж буй төхөөрөмжүүдийн зохистой ашиглалтад хяналт тавьж дэд бүтцийн системийн үзлэг, үйлчилгээний хуваарийг тогтмол хийж ашиглалтыг сайжруулах арга хэмжээг судалгааны үндсэн дээр авч хэрэгжүүлэх, үр ашиггүй ажиллаж буй төхөөрөмжүүдийг тодорхойлж гаргасан байх. | 1 | 1 | • Дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор өдөр тутмын үзлэг, хяналтын ажлуудыг төлөвлөгөөт ажлын дагуу тогтмол хийж гүйцэтгэсэн;<br>- Үндсэн болон нөөц төвийн дэд бүтцийн системд 416 удаагийн үзлэг, үйлчилгээ хийж гүйцэтгэсэн. Ашиглалтын 11 ширхэг техник тоног төхөөрөмжийн паспортыг долоо хоног бүр шинэчлэн хөтөлж, үзлэгээр илэрсэн нийт 32 төрлийн гэмтэл, доголдлыг шуурхай арилгаж, төвийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангасан;<br>- Барилга байгууламжийн тодорхой хэсгүүдэд гэрэлтүүлгийн ашиглалтыг сайжруулах судалгаа хийж, фото реле суурилуулж байгалийн гэрэл хангалттай үед гэрэлтүүлэг автоматаар унтрах нөхцөлийг бүрдүүлсэн;<br>- Үндсэн болон нөөц төвийн хэмжээнд оффисын болон хөргөлтийн төхөөрөмжүүдийн цахилгааны хэрэглээг бууруулах зорилгоор сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх судалгаа хийсэн;<br>- Шаардлагатай фреон, чийгшүүлэгчийн тогоо зэрэг хэрэглэгдэхүүний нөөцийг бүрдүүлж, тасралтгүй үйл ажиллагааг хангасан;<br>- Үндсэн болон нөөц төвийн дэд бүтцийн тоног төхөөрөмжүүдийг нэгдсэн хяналтын системд нэгтгэх судалгаа, туршилтын ажлыг эхлүүлж, нэгдсэн хяналтад оруулах боломжтой тоног төхөөрөмжүүдийн өгөгдлийн мэдээллийг бүрдүүлэн ажилласан. | 100% |
| 5 | **1.1.5** | Барилга байгууламжийн урсгал засвар, гадна тохижилтын засварыг хийж гүйцэтгэх | Дотоод нөөц | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Байгууллагын барилга байгууламжийн гадна, дотор талбайн тохижилтыг хийж гүйцэтгэсэн байх. | 1 | 1 | • Байгууллагын барилга байгууламжийн ашиглалтын нөхцөл, орчны аюулгүй байдал болон ажиллах таатай орчныг бүрдүүлэх тохижилт, засвар үйлчилгээний ажлуудыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн;<br>• Төвийн дээврийн засварын тендерийн материалыг үнэлж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж, ажил | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэлийн хуваарийн дагуу хяналт тавьж засварын ажлыг хийж гүйцэтгэсэн;<br>• Өвөлжилтийн бэлэн байдлыг хангаж төлөвлөгөөний дагуу дулаан, агааржуулалт, эрчим хүчний найдвартай ажиллагааг хангасан. | |
| 6 | **1.1.6** | Төвийн барилга байгууламж, техник тоног төхөөрөмжүүдэд өдөр тутмын үзлэг хийж тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах. | Дотоод нөөц | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Техник тоног төхөөрөмжүүдэд өдөр тутмын үзлэг хийж хэвийн ажиллагааг хангах, тоног төхөөрөмжүүдэд хийгдсэн үйлчилгээ тус бүрийг техникийн паспортод тэмдэглэсэн байх. | 1 | 1 | • Үндсэн болон Нөөц төвийн дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангаж төлөвлөгөөт болон өдөр тутмын үзлэг, хяналтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн;<br>• Дэд бүтцийн техник тоног төхөөрөмжүүдэд 378 удаагийн өдөр тутмын үзлэг хийж, илэрсэн доголдлыг шуурхай арилган, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг тасралтгүй хангаж ажилласан. Үзлэг, үйлчилгээний ажлуудыг баримтжуулж, тоног төхөөрөмжийн техникийн паспортуудад бүрэн тэмдэглэн хөтөлсөн;<br>• Төвийн инженерийн шугам сүлжээнд 2025 оны 6 дугаар сарын 13-аас 8 дугаар сарын 1-ний хооронд төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийж, дэд бүтцийн найдвартай ажиллагааг нэмэгдүүлсэн. | 100% |
| 7 | **1.1.7** | Техник төхөөрөмжүүдийн ажиллагаанд хэвийн бус горим илэрсэн, доголдол гарсан төхөөрөмжүүдийг шуурхай хэвийн ажиллагаанд оруулах | Дотоод нөөц | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Доголдол гарсан тоног төхөөрөмжүүдийг шуурхай засварлах, хэвийн ажиллагаанд оруулж ажиллах, засварын ажлыг техник ашиглалтын паспортад тэмдэглэсэн байх. | 1 | 1 | • Үндсэн болон нөөц төвийн техник тоног төхөөрөмжүүдэд илэрсэн хэвийн бус ажиллагаа, доголдлуудыг тухай бүр шуурхай арилгаж, техник ашиглалтын паспортуудад нийт 32 төрлийн доголдлыг бүртгэн тэмдэглэсэн;<br>• Гуравдагч эх үүсвэрээс шалтгаалж 28 удаа цахилгаан хангамж тасарсан ба дэд бүтцийн тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж сервер тоног төхөөрөмжүүдэд тасалдал үүсээгүй;<br>• Хөргөлтийн төхөөрөмжүүдэд заасан алдааг засварлах зорилгоор “Hyperterminal” программыг худалдан авалтыг хийж хөргөлтийн төхөөрөмжүүдэд заасан “internal communication” алдааг засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Хөргөлтийн төхөөрөмжүүдэд фреон цэнэглэх, чийгшүүлэгчийн тогоо солих, “FW update” хийх зэрэг шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийж, хэвийн ажиллагааг хангасан. | 100% |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.** | | | | | | | | **Хувь** |
| ***НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ, ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 33 дүгээр заалт, ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН ДҮРЭМ 4.1,4.2,4.3.*** | | | | | | | | |
| **1** | | **Зорилт 1. Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **8** | **Гүйцэтгэл** | |
| 8 | **2.1.1** | Төвийн систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, үйл ажиллагаа, үйлчилгээнд ашиглагдаж буй сервер тоног төхөөрөмж, | Дотоод нөөц | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Сервер тоног төхөөрөмж, системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж серверийн сүлжээний кабель ашиглалт зохион байгуулалтын | 1 | 1 | • Серверийн А, Б өрөөнд байрлаж буй 159 байгууллагын 1,399 сервер, төхөөрөмжийн бүртгэлийг шинэчилж, 44 байгууллагын 164 тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлт, суурилуулалтын үйлчилгээ үзүүлж ажилласан;<br>• Төрийн клауд дэд бүтцийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөний дагуу 34 сервер, нөөцлөлтийн дэд бүтцийн 2 сервер, нийт 36 серверийн “Firmware” шинэчлэлтийг хийсэн; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | системийн үйлчилгээг тогтмол гүйцэтгэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | | сайжруулалтуудыг хийсэн байх;<br>б/ Физик сервер, хадгалах төхөөрөмжүүдийн "Firmware" шинэчлэлтийг хийж үндсэн болон дэмжих системүүдийг сүлжээний хувьд физик тусгаарлалт хийсэн байх;<br>в/ Систем, сүлжээний тоног төхөөрөмжийн хувилбаруудыг аюулгүй байдлын шаардлагын хүрээнд тогтмол шинэчлэх, тасалдал бүртгэх системийг сайжруулж мониторингд тогтмол хэрэглэсэн байх. | | | • Үндсэн болон дэмжих системүүдийн сүлжээний тусгаарлалтын ажлын хүрээнд ДАН 2.0 дэмжих системийг шинээр хөгжүүлэхдээ сүлжээний хувьд тусгаарлагдсан виртуал сүлжээнд байршуулсан;<br>• Төвийн сүлжээний архитектурыг шинэчилж, интернэтийн гадаад гарцыг шууд холболттой болгож хэвийн ажиллагаа, найдвартай байдлыг сайжруулсан;<br>• Тайлант хугацаанд байгууллагын доголдлын бүртгэлийн системийг шинэчилж, Microsoft Teams, Domain Controller-тэй холбох интеграцийн хөгжүүлэлтийг хийсэн;<br>• Захирлын А/44 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд хяналт мониторингийн үйл ажиллагааг сайжруулж нийт 1,332ш виртуал болон тоног төхөөрөмжийг нэмж, анхааруулах мэдэгдлийн үр дүнгийн талаар удирдлагад тогтмол танилцуулан сайжруулалт хийж ажиллаж байна. Тасалдал доголдлын системийг сайжруулж нийт 64 доголдол бүртгэж шийдвэрлэсэн;<br>• Сүлжээний гарцын хамгаалалтын галт хана, "DDOS" халдлагаас хамгаалах систем, цахим хуудасны хамгаалалтын төхөөрөмжүүдийн хувилбарын шинэчлэлтийг 2 удаа хийж гүйцэтгэсэн;<br>• Үндсэн сүлжээний 6 свитчийн үйлдлийн системийг 2025 оны 10 дугаар сард гарсан шинэ хувилбараар шинэчилж, илэрсэн 6 CVE эмзэг байдлыг засварласан. | |
| 9 | **2.1.2** | Төрийн байгууллагын цахим шуудангийн системийн ажиллагааг сайжруулах | | Хэрэгжилтээр<br>Тоо:2<br>Чанар: а/ Цахим шуудангийн системийг дэд бүтцийн хувьд тусгаарлаж сүүлийн тогтвортой хувилбар руу шинэчилсэн байх. | 1 | 1 | • Төрийн цахим шуудангийн системийг төлөвлөгөөний дагуу 10.0.6 хувилбараас 10.1.7 хувилбарт шилжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба шинэчлэлийг хийснээр 65 эмзэг байдал засагдсан бөгөөд үүнээс 40 CVE-ээр бүртгэгдсэн 25 CVE-гүй/TBD байна;<br>• Хагас жилийн хугацаанд тус системд нийт 4 удаа доголдол үүссэн ба үүнээс 1 удаа хадгалах төхөөрөмжийн саатлаас 3 удаа программ хангамжийн асуудлаас үүдэлтэй доголдол үүссэн;<br>• Төрийн 727 байгууллагын 1,055 домайнаар 64,412 төрийн албан хаагчдад төрийн цахим шуудангийн үйлчилгээ үзүүлж байна. | 100% |
| 10 | **2.1.3** | Байгууллагын мэдээллийн технологийн программ хангамжуудын лицензийг сунгуулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Албан ёсны лицензтэй программ хангамжийг хэрэглэх, төсвийн хүрээнд лицензжүүлэх чиглэлийг баримталж ажилласан байх. | 1 | 1 | • Төвийн 2025 оны худалдан авалтын нэгдсэн төлөвлөгөө гаргаж хуулийн хугацаанд холбогдох байгууллагаар батлуулан төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-нд нийтэлж, 2025 оны худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн үнэн зөв, ил тод байдлаар мэдээлж, зохион байгуулж ажилласан;<br>• Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд Төрийн цахим шуудангийн системийн лицензийг 80,000 хэрэглэгчээр 2026 оны 8 дугаар сарын 15 хүртэл сунгуулсан. | 100% |
| 11 | **2.1.4** | Төвийн хэмжээнд нөөцлөлтийг | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1 | 1 | 1 | • Нөөцлөлтийн журмын дагуу нөөцлөлтийг 3 түвшнээр, 14 хоног, 7 хоног, 3 хоног болон 60 хоногийн давтамжаар авч, хадгалалт, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдох журмын хүрээнд бүрэн гүйцэтгэх | | Чанар: а/ Нөөцлөлтийг хуваарийн дагуу хийж хяналт тавьж ажилласан байх;<br>б/ Клауд дэд бүтэц, суурь мэдээллийн сангуудын систем нөөцлөлтийг хийж эрсдэлийг бууруулахаар ажилласан байх;<br>в/ Улирал бүр нөөцлөлтөөс сэргээх туршилт хийсэн байх. | | | хяналтыг тогтмол хийж ажилласан. Төрийн байгууллага болон төвийн үйлчилгээний нийт 1,111 виртуал серверээс 879 серверийг 3 түвшний нөөцлөлтөөр хамруулж, 60 хоногоор хадгалалт хийсэн;<br>• Төрийн цахим шуудангийн системийн нөөцлөлтийг сар бүрийн 15, 30-нд авч 180 хоногоор хадгалж, хадгалалтын давтамжийг оновчлох зорилгоор 180 хоногоос давсан хуучин нөөцийг устгаж ажилласан;<br>• Төрийн клауд уламжлалт дэд бүтцийн Avamar нөөцлөлтийн системийн хувилбаруудыг 19.9-с 19.10, DP-4400 төхөөрөмжийн системийг 2.7.4-с 2.7.8 болгон шинэчилж, нөөцлөлтийн дэд бүтцийн найдвартай ажиллагааг сайжруулсан;<br>• Нөөцлөлтийн журамд заасны дагуу улирал бүр сэргээх туршилт хийж, төрийн байгууллагуудын хүсэлтийн дагуу нийт 18 виртуал серверийг нөөцөөс сэргээж, үйлчилгээг хэвийн ажиллагаанд шилжүүлсэн;<br>• Төвийн үйлчилгээний системүүдийн шаардлагын дагуу нийт 6 виртуал серверийг нөөцөөс сэргээж, тест ашиглалтын тайланг сар бүр гарган мэдээллийн тасралтгүй ажиллагааг ханган ажилласан. | |
| 12 | **2.1.5** | Үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөхөд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ажиллах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:2<br>Чанар: а/ Төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх ажлын саналыг хүргүүлж шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх баримт бичиг боловсруулан ажилласан байх;<br>б/ Сүлжээний тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байх;<br>в/ НА редундант нөөц төвийн тоног төхөөрөмжийг суурилуулж ажиллагаанд оруулсан байх. | 1 | 1 | • Шинэ Зуун мод хот дахь шинэ дата төвийн ТЭЗҮ-ийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар боловсруулах судалгаанд дэмжлэг үзүүлсэн;<br>• 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Ухаалаг засаг 2 төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Хиймэл оюун ухааны суурь дэд бүтцийг бий болгох төсөл, Үндэсний дата төвийн суурь дэд бүтцийг дэвшилтэт шийдлээр өргөтгөх төслүүдийн аюулгүй байдлын болон техникийн судалгаа хийж, холбогдох баримт бичгийг боловсруулсан;<br>• Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд сервер 30, хадгалах 1, сүлжээний 15, нөөцлөлт 1, аюулгүй байдлын 3 төхөөрөмжүүдийг хүлээн авч суурилуулснаар тооцоолох хүчин чадал 1.5 дахин, хадгалах нөөц 2 дахин, нөөцлөлтийн хүчин чадал 2 дахин нэмэгдэж дотоод сүлжээний хурд 10G болсон;<br>• НА Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу амжилттай зохион байгуулсан. ШӨХТГ, Сангийн яаманд тендерт оролцогч байгууллагаас гомдол гаргаснаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 13 дугаар зүйлийн 13.1.1-д багтан санхүүжилтийн олголт хийгдээгүй;<br>• Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд Дархан хот дахь нөөц төвийн сэлгэн ажиллах болон үндсэн төвийн сүлжээний дэд бүтцийн | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шинэчлэлт, GPU сервер тоног төхөөрөмжийн саналуудыг боловсруулан, төслийн нэгж болон ЦХИХХЯ-нд хүргүүлсэн. | |
| 13 | **2.1.6** | Үндэсний дата төв дээр байрших төрийн байгууллагуудын системүүдийг IPv6, IPv4 хос технологи руу шилжүүлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ IPv6 технологийг төрийн клауд системд нэвтрүүлж Монгол улсын хэмжээнд интернэтийн хаягжилтын 4 дэх (IPv4) хувилбараас 6 дахь (IPv6) хувилбарт төлөвлөгөөний дагуу шилжүүлсэн байх;<br>б/ Интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийг Layer2 болгож Dual-stack технологиор IPv6-г давхар нэвтрүүлсэн байх. | 0 | 1 | • Үндэсний дата төвд байршин ажиллаж буй Цахим хуудас, Виртуал сервер, физик тоног төхөөрөмж дээр IPv6 нэвтрүүлэх дэд бүтэц болон технологийн нэвтрүүлж ажиллахад бэлэн болсон. Үүнээс Цахим хуудасны үйлчилгээ авч байгаа 606 байгууллагын 1,828 цахим хуудас ipv6 хаягжилттайгаар ажиллаж байна;<br>• Танилт нэвтрэлтийн нэгдсэн "ДАН" системийн гэрээг цахимаар байгуулах "geree.gov.mn", Танилт нэвтрэлтийн нэгдсэн "ДАН" систем "sso.gov.mn" зэрэг системд "IPv6" хаягжилтыг нэвтрүүлсэн<br>• Үндэсний дата төв дээр байрших 165 байгууллагыг IPv6 технологид шилжүүлэх сүлжээний архитектурыг боловсруулж бэлэн байдлыг хангаж төвийн хэмжээнд байрших бүх систем, тоног төхөөрөмж IPv6 хаяг авах боломжтой болсон;<br>• Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийг Dual-stack технологиор нэвтрүүлж, нийт 40 интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллага холбогдсон бөгөөд үүнээс 8 байгууллага IPv6-тэйгээр ажиллаж байна. | 100% |
| 14 | **2.1.7** | Төрийн mCloud системийн дэд бүтцийг өргөтгөх, "Mindgolia" программ хангамжийн их дэлгүүрийн бүтээгдэхүүнийг төрийн үүлэн тооцооллын "mCloud" системд нэгтгэх, системийг HA редундант байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 2<br>Чанар: а/ Нөөц төвд төрийн клауд системийн хуулбарыг бий болгож, сонгогдсон хэрэглэгчид HA редундант нөөц төвөөс ажиллах боломжийг бүрдүүлж системийн хэвийн найдвартай байдлыг хангаж ажилласан байх;<br>б/ ХУР төрийн мэдээлэл солилцооны болон Танилт нэвтрэлтийн системд холбогдох боломж бүхий клиентийг mCloud системд үүсгэсэн байх;<br>в/ Төрийн mCloud системийн дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах, улирал тутам шалгалт хийж тайлан гаргаж ажилласан байх. | 0 | 1 | • Үндсэн төв болон нөөц төвийн хооронд 10гб хүртэлх урсгал МХС-с түрээслэж төрийн клауд дээр байршиж буй 97 байгууллагын 535 виртуал серверийн нөөцлөлтийг хадгалж байна;<br>• НА Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу амжилттай зохион байгуулсан. ШӨХТГ, Сангийн яаманд тендерт оролцогч байгууллагаас гомдол гаргаснаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 13 дугаар зүйлийн 13.1.1-д багтан санхүүжилтийн олголт хийгдээгүй;<br>• ХУР төрийн мэдээлэл солилцооны болон Танилт нэвтрэлтийн системд холбогдох боломжтой клиентийн "image" файлуудыг docker технологи ашиглан бий болгосон;<br>• Төрийн клауд дэд бүтцийг 3 байгууллагаас ирсэн 9 серверээр өргөтгөж, нийт 468 core CPU, 4.7 TB RAM, 18 TB хадгалах нөөц нэмэгдүүлсэн;<br>• http://mindgolia.mn цахим хуудас ажиллахгүй болж домэйн нэрийн хугацаа дууссан тул энэхүү ажил нь төвөөс үл хамааралтайгаар түр хугацаагаар зогссон;<br>• Төвийн эмзэг байдлын удирдлагын журмын дагуу mCloud дэд бүтцийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж, илэрсэн эмзэг байдлын мэдээллийг "Fibocloud" ХХК-д албан бичгээр хүргүүлж хяналт тавьсан. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | **2.1.8** | Үйлчилгээний талаарх мэдээллийг гаргах, нэгдсэн мэдээллийн системийг ашиглалтад бүрэн оруулах, тухай бүр шинэчлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Төвийн үйл ажиллагаанд ашиглагдах нэгдсэн мэдээллийн системийг ажиллагаанд оруулж төвийн хэмжээний тоон мэдээллийн хяналтын нэгдсэн самбарыг тогтмол сайжруулж ажилласан байх;<br>б/ Байгууллагын үйлчилгээний олох боломжтой орлогын мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж ажилласан байх. | 1 | 1 | • Төвөөс үзүүлдэг үйлчилгээ, үйл ажиллагааны нэгдсэн дашбоард систем (info.mndc.gov.mn)-д дараах мэдээллийг нэмэлтээр оруулж шинэчилсэн.<br>- Цахим гэрээний систем (geree.gov.mn)-ийн гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл,<br>- Төрийн үүлэн тооцооллын дэд системийн хяналтын мэдээлэл,<br>- Зурвасын мэдээллийн хяналт,<br>- Үйлчилгээ, гэрээний бүртгэлийн системийн мэдээллүүд багтсан;<br>- Төрийн цахим шуудан, Төрийн цахим хуудас, Зогсуур түрээс, Домэйн нэрийн үйлчилгээний төлбөрийн мэдээллийг байгууллага, үйлчилгээний төрөл, төлбөрийн ангиллаар нэгтгэн байршуулсан;<br>• Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системийн орлогын мэдээллийг жил бүрээр харуулах хөгжүүлэлтийг хийж, дотоод удирдлагын нэгдсэн систем (mgmt.mndc.gov.mn)-д нэгтгэсэн. | 100% |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.** | | | | | | | | |
| ***"АЛСЫН ХАРАА-2050", МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15*** | | | | | | | | **Хувь** |
| | **2** | **Зорилт 2. Төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **1** | **Гүйцэтгэл** | |
| 16 | **2.2.1** | Төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:5<br>Чанар: а/ Мэдээллийн сан бүхий төрийн байгууллагууд болон тэдгээрийн мэдээллийн сангийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж суурь мэдээллийн сангуудын хуулбар баазын ажиллагааг сайжруулж ажилласан байх;<br>б/ HA редундант нөөц төвд ажиллаж буй мэдээллийн сангийн ExaData X4 төхөөрөмжид мэдээллийн сангуудыг хуулбарласан байх. | 1 | 1 | • Төвийн хэмжээнд системийн хандах эрхийн матрицыг шинэчлэн боловсруулж, мэдээллийн сангуудад хандах хандалтыг сүлжээний хамгаалалтын төхөөрөмж дээр тохируулж, хяналтыг сайжруулсан;<br>• Төрийн мэдээллийн сангийн ORACLE ExaData системийн хэвийн найдвартай байдлыг хангах зорилгоор ажиллагаатай байгаа зохиомол серверүүдийг Дархан нөөц төв рүү хуулбарласан;<br>• ХУР системийн ЛОГ бүртгэлийн мэдээллийн санд 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс хойш үүссэн нийт 9.3Т, хуулбар мэдээллийн сан дээр 2025 оны 3 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх нийт 4.4Т өгөгдөл хуулбарлан авсан;<br>• Мэдээллийн сангийн сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор сүлжээний дэд бүтцийн зохион байгуулалтыг тусгаарлах ажлын хүрээнд мэдээллийн санд хандаж буй системүүдийг шилжүүлсэн;<br>• ExaData X4 төхөөрөмжид мэдээллийн сангийн хуулбар үүсгэх бэлтгэл ажлыг хангаж туршилтыг хийсэн. Тус төхөөрөмжийг сэлгэн ажиллах дэд төвийн төслийн ажил хийж дууссаны дараа байршуулна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | **2.2.2** | Монгол Улсад дата серверийн эдийн засгийн хөгжлийг стратегийн түвшинд дэмжих, бодлого боловсруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар манлайлан оролцох, энэ салбарын тэргүүлэгч байгууллага болох | | Хэрэгжилтээр<br>Тоо:<br>Чанар: а/Дата серверийн эдийн засгийн хөгжлийн бодлого боловсруулах;<br>б/ Салбарын хөгжлийн стратеги, төлөвлөгөөний дагуу бодлого хэрэгжүүлэх төслүүд санаачлах, хэрэгжүүлэх;<br>в/ Стратегийн түвшний хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа хөгжүүлэх | 1 | 1 | • Төв нь хөрөнгө оруулалт татах, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:<br>- Монгол улсын дижитал шилжилтийн бодлогын хүрээнд мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, үндэсний дата төвийн стратегийг тодорхойлох зорилгоор "Дата төвийн боломж ба сорилт" сэдэвт стратегийн түвшний уулзалтыг суурь судалгааны ажлын эхлэл болгон зохион байгуулсан бөгөөд уулзалтад төр болон хувийн хэвшлийн 20 гаруй байгууллагын 60 орчим төлөөлөл оролцсон. Уулзалтаар Монгол улсыг бүс нутгийн дата төвийн зангилаа төв болгох боломж, үндэсний чадамж, олон улсын туршлага, дижитал хөгжилтэй уялдах стратегийн гол тулгуур чиглэлүүдийг хэлэлцэж, дараах бодлогын багц чиглэлүүдийг тодорхойлон гаргасан;<br>- Европын Холбооны "Ерөнхий өгөгдөл хамгаалах тухай хууль" (GDPR) болон "Өгөгдлийн засаглалын тухай хууль" (EU) 2022/868-ыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, эрх зүйн зохицуулалттай харьцуулсан судалгааг боловсруулж байгаа бөгөөд энэ нь өгөгдлийн хамгаалал, зохистой ашиглалтыг олон улсын жишигт нийцүүлэхэд чиглэж байна;<br>• Олон улсын дата төвийн чиг хандлагын хүрээнд Сингапур, Малайз зэрэг улсуудын шинээр дата төв байгуулахад баримталж буй хөрөнгө оруулалтын санхүүгийн хөшүүрэг, технологийн болон ногоон бодлого зэрэг шилдэг туршлагыг судалж, Монгол улсад нутагшуулахад тохиромжтой арга замыг тодорхойлох судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 18 | **2.2.3** | Мэдээллийн аюулгүй байдал, системийн уялдаа холбоог хангах үндэсний өгөгдөл солилцооны платформ хөгжүүлэхэд мэргэжлийн оролцоог хангаж, технологийн загварчлал, бодлогын зөвлөмж, шаардлагатай арга хэмжээний | - | Хэрэгжилтээр<br>Тоо:<br>Чанар: а/ Технологийн загварчлал боловсруулах;<br>б/ Бодлогын зөвлөмж, шаардлага боловсруулж танилцуулах;<br>в/ Системийн туршилт, туршилтын орчныг бий болгож зохион байгуулалт, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх; | 1 | 1 | • Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.3-т заагдсан үндсэн систем болох төрийн мэдээлэл солилцооны хур системийг тархмал бүтцэд шилжүүлэх ажлын "Бие даасан техникийн зөвлөх Хур систем"-ийн зөвлөх үйлчилгээний тендер Ухаалаг засаг 2 төслийн нэгжид амжилттай зарлагдсан. Гэрээт ажлын явц, гүйцэтгэлийг хянан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЦХИХХЯ-ны төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн дарга Д.Батбаяраар ахлуулж 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулагдсан. Нийт 4 удаа хуралдаж, зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан баримт бичигтэй танилцаж, шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан;<br>• Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд тус ажлын гэрээ хийгдсэн бөгөөд Үндэсний дата төвөөс тендерийн баримт бичигт шаардлагатай техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг боловсруулж хүлээлгэн өгсөн. | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг зохион байгуулах. | | | | | | |
| 19 | **2.2.4** | Олон улсын шилдэг туршлага, технологийг нутагшуулах, хамтарсан төсөл, хөрөнгө оруулалтыг татах замаар гадаад хамтын ажиллагааг стратегийн түвшинд өргөжүүлэн хөгжүүлэх. | | Хэрэгжилтээр<br>Тоо:<br>Чанар: а/ Туршлага судлах, нутагшуулах, гадаад түншлэл, хамтын ажиллагаа хөгжүүлэх;<br>б/ Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад хөрөнгө оруулалт татах,<br>в/ Чадавх бэхжүүлэх, олон улсын сургалт, солилцоонд хамруулах | 1 | 1 | • Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.1-д заасан танилт, нэвтрэлтийн “Дан” системийг шинэчлэн, үндэсний баталгаажуулагч аппликейшн болгон хөгжүүлэх ажлыг Үндэсний дата төв нь И-Монгол Академитай хамтран хэрэгжүүлсэн. Энэхүү шинэчлэлийн ажил 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдөр бүрэн дуусаж “production” орчинд нэвтрүүлсэн;<br>• Төвийн МАБ-г сайжруулах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйлдвэрлэгч байгууллагатай уулзалт зохион байгуулан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээтэй танилцаж цаашдын хамтын ажиллагааны талаар дараагийн шатны уулзалт арга хэмжээг төлөвлөн ажилласан;<br>• 2025 оны 09 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Вьетнам улсад зохион байгуулагдсан “Exabeam Security Intelligence Summit” олон улсын арга хэмжээнд оролцож мэдээллийн аюулгүй байдлын менежмент (SIEM) системийн талаар судалгаа, шинжилгээ хийж үр дүнг танилцуулж цаашдын үйл ажиллагаанд ашиглах боломжуудыг судалсан. | 100% |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. *НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.*** | | | | | | | | **Хувь** |
| ***“АЛСЫН ХАРАА-2050”, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15, ТӨРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГААС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ*** | | | | | | | | |
| ***3*** | | **Зорилт 3. Төрийн мэдээлэл солилцооны үйлчилгээ үзүүлэх;** | **-** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **5** | **Гүйцэтгэл** | |
| 20 | **2.3.1** | Төрийн болон хувийн байгууллагуудад үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ ЦХХХЯ-тай хийсэн гэрээг үндэслэн төрийн болон хувийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан байх. | | 1 | • Үндсэн болон дэмжих системтэй холбоотой 4,457 хүсэлт хүлээн авч шийдвэрлэн ажилласан. Хамгийн ихээр давтагддаг, нийтлэг үүсдэг хүсэлтийг шийдвэрлэхээр шифрлэлтийн гарын авлага, видео контентыг бэлтгэн “guide.datacenter.gov.mn”-д байршуулсан;<br>• Үндсэн болон дэмжих системийн Цахим гэрээний “Geree.gov.mn” системээр тайлант хугацаанд нийт 571 гэрээг байгуулснаас ХУР системд холбогдох үндсэн болон нэмэлт нийт 416, ДАН системд холбогдох үндсэн болон нэмэлт нийт 155 гэрээг байгуулсан;<br>• Тайлант хугацаанд нийт Төр болон хувийн хэвшлийн байгууллагуудаас ирсэн 35 албан тоот, цахим шуудангаар ирүүлсэн 4,342 хүсэлтийг тус тус шийдвэрлэж харилцагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн ажилласан;<br>• Эрүүл мэндийн салбарын систем хөгжүүлэгч байгууллага (МИТПС ХХК, Клиник ХХК, Метронэтворкс ХХК, Аксис системс ХХК, Вингс Гоо ХХК, Дижитал Андмед ХХК, Маргад Оньс ХХК)-уудыг ЦХИХХЯ-аас ирсэн 03/436 дугаартай баримт бичгийн дагуу | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл Үндсэн систем "ХУР"-ыг төлбөргүй ашиглах тохиргоо хийсэн. | |
| 21 | 2.3.2 | Танилт, нэвтрэлтийн системийг шинэчлэх, үндэсний баталгаажуулагч аппликейшнийг бий болгох | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар:<br>а/ Танилт нэвтрэлтийн систем үндэсний баталгаажуулагч аппликейшнийг хөгжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байх;<br>б/ Тухайн системийг тасралтгүй хөгжүүлж нэгтгэх, шалгах боломжтой микорсервис системийн архитектур бүхий системийн орчныг бий болгосон байх. | 1 | 2 | • Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.1-д заасан танилт, нэвтрэлтийн "ДАН" системийг шинэчлэн, үндэсний баталгаажуулагч аппликейшн болгон хөгжүүлэх ажлыг Үндэсний дата төв нь И-Монгол Академитай хамтран хэрэгжүүлж, 2025 оны 10 дугаар сарын 18-нд шинэчлэгдсэн системийг "production" орчинд бүрэн нэвтрүүлсэн. "ДАН2.0"-ийн аппликейшны шинэ боломжууд:<br>QR код уншуулан хялбар нэвтрэх<br>Албан хаагчдын хохийн бүртгэл үүсгэх, удирдах<br>Deep Link технологиор аппликэйшн хооронд баталгаажсан нэвтрэлт хийх<br>Тоон гарын үсгээр цахим гэрээ байгуулах, баталгаажуулах<br>Төрийн "ХУР" системийн үндсэн баталгаажуулах суваг болох<br>- Нотариатын итгэмжлэлээр нэвтрэх боломж (өөрийн өмнөөс нэвтрэх эрх олгох)<br>- Гадаадад буй монголчуудад зориулагдсан гадаад гар утасны дугаараар бүртгүүлэх боломж<br>- Хуулийн этгээдийн нэвтрэлтийг хялбаршуулсан шинэ төрөлтэй болсон;<br>• Системийг тасралтгүй хөгжүүлэх, нэгтгэх, шалгах боломжтой микросервис архитектур бүхий системийн орчныг Үндэсний дата төвийн кубернетс дэд бүтцэд бий болгохоор төлөвлөж, 3 мастер, 6 воркер серверийн бүтэцтэйгээр зохион байгуулсан. | 100% |
| 22 | **2.3.3** | Хэрэглэгчийн дуудлага хүлээн авах "Callcenter"-ийн зохион байгуулалтыг сайжруулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Төвийн бизнес төлөвлөлтөд тусгагдсан үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй үзүүлж хэрэглэгчийн дуудлага хүлээн авах шат дараалыг нарийвчилж, дуудлага алдах хугацааг багасгах замаар дуудлагын "callcenter" зохион байгуулалтыг сайжруулсан байх. | | 1 | • Төвийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хэрэглэгчийн дуудлагыг алдахгүй хүлээн авах зорилтын хүрээнд "Callcenter"-ээр нийт 23 125 дуудлагад хариу өгч, бүртгэлийн системд бүртгэн шийдвэрлэн ажилласан. Ирсэн дуудлагын давтамжийг хянаж, давхардлыг арилгах арга хэмжээг авч, нэг хэрэглэгчийн олон дуудлагыг нэгтгэн боловсруулсан;<br>• 2025 онд нийт ачаалал 45.8%-иар, алдсан дуудлагын тоо 74.7%-иар буурч, хяналт шинжилгээ болон хариу өгөх чадвар сайжирсан;<br>• Алдагдлын түвшин 2025 онд 10.68 функцээр буурч, өмнөх онтой харьцуулахад алдагдлын хувь нийтдээ 53%-иар сайжирсан;<br>• "AllCall" системийн ашиглалтыг нэвтрүүлснээр дуудлагын хүлээлгийн хугацаа багасаж, ажилтнуудын хариу үйлдлийн хурд нэмэгдсэн. | 100% |
| 23 | **2.3.4** | Хэрэглэгчийн үйлчилгээ болон дотоод системүүдийн | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 3<br>Чанар: а/ Ашиглаж буй системүүдийн бичиг баримт, | | 1 | • Танилт, нэвтрэлтийн нэгдсэн "ДАН" системийн 2.0 хувилбар болон Цахим гэрээний "geree.gov.mn" системийн хэрэглэгчийн гарын авлагыг боловсруулж, байгууллагын гарын авлагын "guide.datacenter.gov.mn" цахим систем болон "geree.gov.mn" | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гарын авлагын систем нэвтрүүлэх | | гарын авлага, техникийн картыг боловсруулж холбогдох системүүдэд байршуулсан байх;<br>б/ VMWare суурьтай системүүдийг төрийн клауд системд шилжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байх. | | | системд байршуулсан. Энэхүү цахим гарын авлагад Цахим гэрээ (geree.gov.mn), ХУР, Домэйн, Зохиомол сервер, ДАН, Төрийн байгууллагын цахим хуудас, Цахим хуудас, Төлбөрийн биллинг систем, Төрийн цахим шуудан зэрэг үйлчилгээнүүдийн заавар, гарын авлагыг нэгтгэн байршуулсан бөгөөд ирж буй хүсэлтүүдийг бууруулах зорилгоор хэрэглэгчдийг гарын авлагын систем рүү чиглүүлэн ажилласан;<br>• VMWare суурьтай vcsa.gov.mn дээр нийт 858 систем ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 01 дүгээр сараас шинээр ирүүлж буй системүүдийг “Mcloud” системд байршуулан ажиллаж, нийт 168 зохиомол сервер шинээр үүссэн. “Mcloud”-г төрийн нэгдсэн сүлжээнд оруулснаар зохиомол серверийн дэд бүтцээс системүүдийг шилжүүлэх боломж бүрдэж, төрийн нэгдсэн сүлжээнд оруулах бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн. | |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. *НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.*** | | | | | | | | **Хувь** |
| ***“АЛСЫН ХАРАА-2050”, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15, ТӨРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГААС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ*** | | | | | | | | |
| **4** | | **Зорилт 4. Төрийн байгууллагуудад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх;** | **-** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **3** | **Гүйцэтгэл** | |
| 24 | **2.4.1** | Үндэсний цахим шуудангийн системийн дэд бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Үндэсний цахим шуудангийн системийн сайжруулалтыг хийсэн байх. | 1 | 1 | • Үндэсний цахим шуудангийн системд нийт 2,225,756 хэрэглэгч байгаагаас 2025 оны хагас жилд 63,623 хэрэглэгч шинээр бүртгүүлсэн;<br>• Үндэсний цахим шуудангийн системийн удирдлага swarm manager-н шинэчлэлийг хийсэн. НА Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу амжилттай зохион байгуулсан. ШӨХТГ, Сангийн яаманд тендерт оролцогч байгууллагаас гомдол гаргаснаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 13 дугаар зүйлийн 13.1.1-д багтан санхүүжилтийн олголт хийгдээгүй. | 100% |
| 25 | **2.4.2** | Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, машин сургалтын дэд бүтцийг бий болгох бэлтгэл ажлыг хангах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Их өгөгдлийг боловсруулах, машин сургалт, хиймэл оюун ухааныг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх суурь дэд бүтцийн судалгаа хийж 2026 оны | 1 | 1 | • Энэхүү ажлын хүрээнд “Vertica” систем дээр ХУР системийн лог бүртгэлийн өгөгдлүүдийг боловсруулж “BI” хэрэгслээр тоон статистик гаргасан. Мөн их өгөгдөл боловсруулахад шаардлагатай дэд бүтцийн тооцоо, төлбөртэй болон үнэгүй шийдлүүдийн харьцуулалт, улсын хэмжээнд их өгөгдлийн боловсруулалтад ашиглагдаж болох мэдээллийн сангуудын судалгааг хийж саналыг ЦХИХХЯ-нд хүргүүлсэн. “Datalake” үүсгэх туршилтын дэд бүтцийг бий болгох гүйцэтгэгч компанитай хамтран ажилласан; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрт тусгасан байх. | | | • Их өгөгдөл, хиймэл оюуны суурь дэд бүтцийг бий болгоход шаардлагатай Ai сервер 4ш, тооцоолох сервер 3, сүлжээний 4, хадгалах төхөөрөмж 2 нөөцлөлтийн төхөөрөмж 1 нийт 14 тоног төхөөрөмжийн техникийн шаардлагыг боловсруулж Ухаалаг засаг 2 төсөлд тусгуулсан. | |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. *НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.*** | | | | | | | | **Хувь** |
| ***"АЛСЫН ХАРАА-2050", МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15, ТӨРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГААС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ*** | | | | | | | | |
| | **5** | **Зорилт 5. Төрийн байгууллага болон иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу мэдээллийн үйлчилгээгээр хангах;** | **-** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **1** | **Гүйцэтгэл** | |
| 26 | **2.5.1** | Байгууллагын үйлчилгээ үзүүлэх системийг автоматжуулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Хэрэглэгчийн үйлчилгээний системийг бүрэн шинэчлэн сайжруулах замаар автоматжуулсан нэгдсэн системтэй болсон байх;<br>б/ Төрийн үйлчилгээний гэрээг цахимжуулсан байх;<br>в/ Байгууллагын цахим хуудсыг шинэчилсэн байх. | | 1 | • Байгууллагын үйлчилгээтэй холбоотой Танилт нэвтрэлтийн нэгдсэн системийн хэрэглэгчийн эрх сэргээх, холбогдсон байгууллагын мэдээллийг шалгах, доголдол бүртгэх, харуулах, мэдээлэх, Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системийн дэлгэрэнгүй лог бүртгэл, төлбөрийн мэдээлэл, лиценз бүртгэл, гэрээ, үйлчилгээний холболт зэрэг мэдээллийг дотоод нэгдсэн удирдлагын "mgmt.mndc.gov.mn" системд нэгтгэсэн;<br>• Хэрэглэгчийн үйлчилгээний системийг нэгдсэн удирдлагын системтэй холбосноор тоон мэдээлэл, статистик, шийдвэрлэлтийн явцыг хянах боломжийг бүрдүүлсэн;<br>• Үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, системийн уялдаа холбоо, процессын оновчлолыг сайжруулах зорилгоор "Ай Ти Инсайт" ХХК-тай хамтран үйлчилгээ тус бүрийн процессын зураглалыг шинэчлэн гаргасан;<br>• Үндсэн болон дэмжих системийн гэрээг 100% цахимаар байгуулах боломжтой geree.gov.mn системийг амжилттай нэвтрүүлж, тохиргооны файлыг автоматаар үүсгэж нууцлалтай цахим шуудан илгээх үйлчилгээг бүрдүүлсэн. Үүний хүрээнд нийт 571 гэрээ байгуулснаас ХУР системд холбогдох үндсэн болон нэмэлт 416, ДАН системд холбогдох үндсэн болон нэмэлт 155 гэрээг цахимаар байгуулсан;<br>• "geree.gov.mn" системийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор тус системд эмзэг байдлын шалгалт хийж илэрсэн ноцтой болон өндөр түвшний эмзэг байдлыг засварласан;<br>• Байгууллагын цахим хуудсыг нээлттэй мэдээллийн ил тод байдлын хуулийн дагуу шинэчилсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. *НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.*** | | | | | | | | **Хувь** |
| ***"АЛСЫН ХАРАА-2050", МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15, ТӨРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГААС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ*** | | | | | | | | |
| **6** | | **Зорилт 6. Монголын интернэтийн харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх;** | **Ухаалаг засаг-2** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **1** | **Гүйцэтгэл** | |
| 27 | **2.6.1** | Монголын интернэтийн харилцан холболтын тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах | Ухаалаг засаг-2 | Хэрэгжилтээр,<br>Тоо:1<br>Чанар: а/ Layer2 технологи руу шилжүүлсэн байх;<br>б/ Интернэтийн харилцан холболтын нөөц төхөөрөмжийг бий болгосон байх;<br>в/ МИХХ, ҮДТ хоорондын интернэтийн гадаад гарцын нэмэлт холболтын хурдыг сайжруулж, сүлжээний архитектур зохион байгуулалтыг шинэчилсэн байх. | | 1 | • Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд Интернэтийн харилцан холболтыг сайжруулах ажлын дагуу нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг хүлээн авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу АТС32 (Төв шуудан) байрлалд 2 ширхэг, АТС45 (Жуков) байрлалд 1 ширхэг төхөөрөмжийг суурилуулж, High Availability (HA) орчин бүрдүүлэн ажиллагаанд оруулсан. Уг ажлын үр дүнд Интернэтийн харилцан холболт Layer2 технологийн түвшинд шилжин, нийт 40 байгууллага холбогдон ажиллах техникийн боломжийг бүрдүүлсэн. Мөн АТС45 буюу МХС-ийн Жуков салбарт нөөц төхөөрөмжийг байршуулах замаар газарзүйн хувьд бие даасан, тасралтгүй ажиллагааг хангах нөөцлөлтийн нөхцөл бүрдүүлж интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд тус төхөөрөмж рүү холбогдох хүсэлт гарган холбогдох бүрэн боломжтой болсон;<br>• Үндэсний дата төвийн олон улсын интернэтийн гарцыг сайжруулах хүрээнд дундын төхөөрөмжөөр дамжуулах шаардлагагүй, шууд "Жемнэт" ХХК-ийн холболт хийж үндсэн сүлжээний архитектурт шинэчлэлт хийж хэрэгжүүлснээр дундын төхөөрөмжийн боломжит гэмтэл, тасалдлын нөлөөллөөс ангид, найдвартай, тасралтгүй интернэтийн гадаад гарцтай болох нөхцөлийг бүрдүүлсэн. | 100% |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 2. *НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛНА.*** | | | | | | | | **Хувь** |
| ***"АЛСЫН ХАРАА-2050", МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15.*** | | | | | | | | |
| **7** | | **Зорилт 7. Контентын харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **0** | **4** | **Гүйцэтгэл** | |
| 28 | **2.7.1** | Толин серверүүдийн аюулгүй байдал болон мэдээллийг тогтмол сайжруулах | - | Хэрэгжилтээр,<br>Тоо: 1<br>Чанар: а/ Линукс үйлдлийн системүүдийн толин серверийн системийн ажиллагааг хянаж ажилласан байх. | 0 | 1 | • Толин серверт "Centos" болон "Ubuntu" үйлдлийн системүүдийн шинэчлэлийг тогтмол байршуулж, хэвийн ажиллагааг хангаж ажилласан;<br>• Толин серверийн үйлчилгээг улсын хэмжээнд найдвартай үзүүлж, нийт 25,259,901 хүсэлтэд 81 ТВ файл таталтыг амжилттай гүйцэтгэсэн; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Толин серверийн үйлчилгээний хандалт, таталтын мэдээллийг https://mirror.datacenter.gov.mn сайтаар дамжуулан хянаж, системийн найдвартай ажиллагааг тогтмол ханган ажилласан. | |
| 29 | **2.7.2** | Цахим системийн эх кодыг аюулгүй, найдвартай хадгалж, тасралтгүй нэгтгэх, түгээх, хөгжүүлэх, эх кодын аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлсэн нэгдсэн дэд бүтцийг бий болгож төрийн байгууллагуудад эх кодын хувилбар удирдах систем "GITLAB" -ийн үйлчилгээг үзүүлэх | - | Хэрэгжилтээр,<br>Тоо:1<br>Чанар: а/ Тухайн системийг нэвтрүүлж үйлчилгээг үзүүлж эхэлсэн байх. | 0 | 1 | • Төрийн байгууллагуудад эх кодын хувилбар удирдах систем “GITLAB”-ийн үйлчилгээг үзүүлэх тендерийн ХАА-ны бичиг баримтыг боловсруулан ЦХИХХЯ-нд хүргүүлсэн бөгөөд тендер 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр үр дүн гарсан болович тендерийн санхүүжилт нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилтийн олголт хийгдээгүй тул ЦХИХХЯ-аас гэрээ хийгдэж худалдан авах ажиллагаа явагдахгүй тухай мэдэгдсэн;<br>• Үндэсний дата төв нь ХУР үндсэн систем, ДАН танилт нэвтрэлтийн дэмжих системийн эх кодын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд ҮДТ дээр 5 GITLAB хэрэглэгчийн эрхийг худалдан авч дата төв 3 эрхийг, 2 эрхийг И-Монгол академид хуваарилан эх кодын аюулгүй байдлыг хангаж ажилласан. | 100% |
| 30 | 2.7.3 | Дотоодын хэрэглэгчдэд зориулсан нийтийн “Docker image registry” хадгалалтын үйлчилгээг бий болгох | - | Хэрэгжилтээр,<br>Тоо: 1<br>Чанар: а/ Төрийн клауд үйлчилгээнд ашиглах “Docker image” байршуулах үйлчилгээг бий болгож ашиглаж эхэлсэн байх. | 0 | 1 | • Төрийн клауд үйлчилгээнд зориулсан “Docker image” байршуулах системийг үүсгэн төрийн клауд системийн 98 байгууллагын 541 зохиомол сервер тус DOCKER REGISTRY толин серверийг ашиглаж эхэлсэн. | 100% |
| 31 | **2.7.4** | Байгууллагын үйлчилгээнд ашиглагдах “агуулга хүргэх сүлжээ” /CDN/ серверийг бий болгох | - | Хэрэгжилтээр,<br>Чанар: а/ Агуулга “Content” байршуулах сервер бий болгосон байх;<br>б/ Цахим хуудас, сервисүүдэд ашиглагдах CDN серверт байршиж буй эх кодын сангуудад тогтмол шинэчлэлтийг хийсэн байх. | 0 | 1 | • Байгууллагын үйлчилгээнд ашиглагдах агуулга хүргэх сүлжээ (CDN) серверийг бий болгох зорилтын дагуу Ухаалаг засаг 2 хүрээнд 30 ширхэг сервер, хадгалах төхөөрөмжүүдийг хүлээн авч суурилуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлээ. Уг төхөөрөмжүүдийг ашиглалтад оруулснаар 1PB хүртэл хэмжээтэй файлын хадгалалтын нөөц бий болсон. | 100% |

| ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 3. *НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, ДЭД БҮТЦИЙН ХЭВИЙН, ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.* | | | | | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| *"АЛСЫН ХАРАА-2050", МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15* | | | | | | | | |
| 1 | | Зорилт 1. Систем, сүлжээ болон орчны аюулгүй байдлыг хангах; | Төсөв | Шалгуур үзүүлэлт | 1 | 4 | Гүйцэтгэл | |
| 32 | 3.1.1 | Төвийн гал болон нэвтрэлтийн системийн найдвартай ажиллагааг хангах | - | Хэрэгжилтээр<br>Тоо2<br>Чанар: а/ Нэвтрэлтийн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, доголдлыг арилгасан байх;<br>б/ Галын аюулгүйн системийн хэвийн ажиллагааг тогтмол шалгаж сайжруулсан байх. | 1 | 1 | • Төвийн нэвтрэлтийн системийн хэвийн ажиллагааг тухай бүр хангаж ажилласан, тайлант хугацаанд доголдол бүртгэгдээгүй;<br>• Галын аюулгүй байдлын системийн ажиллагааг сар бүр тогтмол шалгаж, бүртгэл хөтөлсөн;<br>• Галын системийн дулаан болон утаа мэдрэгчүүдэд тайлант хугацаанд 2 удаа зохиомлоор дулаан, утаа үүсгэж, ажиллагааг шалгаж баталгаажуулсан. Шалгалтын явцад нийт 7 тоног төхөөрөмж ажиллахгүй байсныг сольж шинэчлэн хэвийн ажиллагааг хангасан. | 100% |
| 33 | 3.1.2 | Төвийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах ачаалал, ажиллагааны туршилтыг тогтмол зохион байгуулах | | Хэрэгжилтээр<br>Тоо: 2<br>Чанар: а/ Илэрсэн зөрчил, дутагдал, эрсдэлийг арилгаж системүүд дээр стресс тестийн төлөвлөгөөг гаргаж системийн судалгааг хийсний үндсэн дээр нэвтрүүлэх боломжийг хоёроос доошгүй удаа турсшан байх;<br>б/ Дэд бүтцийн техник төхөөрөмжүүдийн ашиглалтын туршилтыг гүйцэтгэсэн байх. | | 1 | • Төвийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн хангах зорилтын хүрээнд дэд бүтэц, системүүдийн ачаалал, ажиллагааны туршилтыг тогтмол зохион байгуулж, илэрсэн эрсдэл, дутагдлыг арилгах арга хэмжээг шат дараатайгаар авч ажиллалаа. Үүнд:<br>- Системийн ачааллын болон стресс тестийн туршилт<br>◦ Танилт нэвтрэлтийн системийн зурвас илгээх Redis Cluster серверт ачааллын туршилт хийж, өмнөх архитектур нь өндөр ачаалал даах боломжгүй байсан тул "3 master + 3 slave" бүтэцтэй болгон сайжруулж, зохиомол серверийн дэд бүтцэд бүрэн шилжүүлэн найдвартай ажиллагааг хангаж ажилласан;<br>◦ Танилт нэвтрэлтийн системийн 2.0 хувилбарт ашиглагдах Kubernetes дэд бүтцийн микросервисүүдэд туршилтын 10 хэрэглэгчээр 5000, 10000, 20000 зэрэг хүсэлтүүдийг зэрэг илгээж ачааллын шалгалт хийж, системийн гүйцэтгэл, хариу өгөх чадварыг шалгасан;<br>◦ Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас www.gov.mn системд туршилтын 50 хэрэглэгчээр 100–500 зэрэг хүсэлт илгээж ачааллын шалгалт хийж, үр дүнг ЦХИХХЯ-д хүргүүлсэн;<br>- Төвийн дэд бүтцийн техник, тоног төхөөрөмжийн туршилт<br>◦ 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр төвийн сүлжээний гарцын үндсэн төхөөрөмжид үйлдвэрлэгчийн талаас тогтоогдсон алдааг засварлах ажлыг гүйцэтгэхдээ сүлжээний урсгалыг түр хааж, хэвийн ажиллагааг сэргээж ажилласан;<br>◦ Төвийн дэд бүтцийн тоног төхөөрөмж, дизель генераторт тогтмол хяналт тавьж, 5 дахь өдөр бүр 11:00–11:30 цагийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ◦ хооронд нийт 35 удаа туршилтын асаалт хийж хэвийн ажиллагааг баталгаажуулсан;<br>◦ 2×150 кВА хүчин чадалтай UPS-ийн батарейн тестийг 14 хоног тутам хийсэн;<br>◦ Төвийн тоног төхөөрөмжүүд болон дизель генераторын ажиллагааг тогтмол хянаж, илэрсэн анхааруулга, алдааг тухай бүр шуурхай засварлан хэвийн ажиллагааг хангаж ажилласан;<br>◦ Тайлант хугацаанд Нөөц төвийн дэд бүтцэд ачаалалтай туршилтыг 3 удаа зохион байгуулж, зөрчил, доголдол илрээгүй;<br>◦ Төрийн зохиомол серверүүдийн найдвартай байдлыг хангахын тулд ажиллагаатай байгаа серверүүдийг Дархан нөөц төв рүү давхарлан хуулбарлаж, өгөгдлийн найдвартай байдлыг сайжруулсан. | |
| 34 | **3.1.3** | Төвийн систем, цахим шуудан, цахим хуудсанд хийгдсэн мэдээллийн аюулгүй байдлын шалгалтын дагуу эмзэг байдлуудыг арилгах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:2<br>Чанар: а/ Жагсаалтад орсон систем, цахим хуудаснуудад аюулгүй байдлын шалгалтаар илэрсэн эмзэг байдлыг тухай бүр арилгаж ажилласан байх. Арилгах боломжгүй эмзэг байдлуудыг тодорхойлж /exception/-д бүртгэсэн байх. | | 1 | • Төрийн цахим шуудангийн системд 3 удаа, Төрийн клауд системд 1 удаа системийн шинэчлэл хийж системийн эмзэг байдлыг засварласан. Төрийн цахим шуудангийн системийг 10.1.13 хувилбар руу шинэчилснээр өмнөх хувилбарын ноцтой эмзэг байдлуудыг засаж, дараах гурван эрсдэлийг бүрэн арилгасан;<br>- Гадны халдлагаас хамгаалсан: Сервер рүү гаднаас нэвтэрч, мэдээлэл хулгайлах болон серверийг хяналтдаа авах боломжтой байсан ноцтой цоорхойг хаасан;<br>- Хэрэглэгчийн мэдээллийг хамгаалсан: И-мэйлээр дамжих хортой кодоос сэргийлж, хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үг алдагдах эрсдэлийг бууруулсан;<br>- Удирдлагын аюулгүй байдлыг сайжруулсан: Админ эрхтэй хэрэглэгч рүү чиглэсэн зорилтот халдлага үйлдэх боломжийг хязгаарласан. | 100% |
| 35 | **3.1.4** | Сүлжээний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн болон төвийн дэд сүлжээний холболтыг SDN рүү шилжүүлэх; | - | Хэрэгжилтээр<br>Тоо:2<br>Чанар: а/ Сүлжээний уламжлалт архитектурын зохион байгуулалтыг өөрчилж орчин үеийн архитектурт шилжүүлсэн байх;<br>б/ Хэрэглэгчийн болон төвийн дэд сүлжээний тусгаарлалт хийсэн байх;<br>в/ Серверийн өрөөний сүлжээний кабель ашиглалт зохион байгуулалтыг сайжруулсан байх. | 1 | 1 | • Сүлжээний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн болон төвийн дэд сүлжээний холболтыг SDN рүү шилжүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Сүлжээний уламжлалт архитектур болон хэрэглэгч төвийн физик тоног төхөөрөмжийн түвшний тусгаарлалтыг ACI технологийн шийдлээр шинэчлэх ажлыг “Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерийн техникийн шаардлагад тусгасан НА Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу амжилттай зохион байгуулсан. ШӨХТГ, Сангийн яаманд тендерт оролцогч байгууллагаас гомдол гаргаснаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 13 дугаар зүйлийн 13.1.1-д багтан санхүүжилтийн олголт хийгдээгүй; | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - МАБГ-аас сүлжээний тусгаарлалт болон аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан;<br>- Батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт 167 VLAN үүсгэн сүлжээний төхөөрөмжүүдэд тохиргоо хийж, VxRail дэд бүтцийн системүүдэд шинэ хаяг олгох ажлыг бүрэн гүйцэтгэсэн;<br>• Серверийн А болон Б өрөөний нэгдсэн бүртгэлийг гаргаж, байршуулсан системүүдэд өдөр бүр хяналт, шалгалт хийж, серверүүдэд илэрсэн 29 байгууллагын 40 төхөөрөмжийн алдааны мэдээллийг тухай бүр бүртгэж мэдээлэл хүргүүлж алдааг засварлуулсан;<br>• Серверийн өрөөний сүлжээний кабелийн ашиглалт, зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж худалдан авалтын гэрээг байгуулсан. Гэрээний хэрэгжилт хангалтгүй байсан тул зохих гэрээг цуцалсан. | |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 3. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, ДЭД БҮТЦИЙН ХЭВИЙН, ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | **Хувь** |
| ***"АЛСЫН ХАРАА-2050", МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15*** | | | | | | | | |
| **2** | | **Зорилт 2. Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **4** | **Гүйцэтгэл** | |
| 36 | **3.2.1** | Төрийн байгууллагуудын цахим шуудангийн системийн аюулгүй байдлыг хангах | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Цахим шуудангийн хамгаалалтын систем дээр илэрсэн вирус спамуудад дүн шинжилгээг хийж холбогдох тохиргооны нарийвчлалыг хийж ажилласан байх;<br>б/ Системийн хэрэглэгч төрийн байгууллагуудад аюулгүй байдалтай холбоотой заавар зөвлөгөөг өгч ажилласан байх. | 1 | 1 | • Цахим шуудангийн системийн хамгаалалтын төхөөрөмжийн хэвийн найдвартай байдлыг хангах хүрээнд харилцагч байгууллагуудаас ирсэн хүсэлтүүдийг шийдвэрлэн ажиллав. 2025 оны 12 сарын байдлаар 32,933,524 цахим шуудан дамжсанаас 15,845,823 буюу 48.11% спам болон сэжигтэй цахим шууданг хаасан;<br>• Төрийн цахим шуудангийн системд нийт 2 удаагийн patch update гүйцэтгэсэн. Үүнд:<br>- 2025 оны 05 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд системийн томоохон хувилбар шинэчлэлт хийж, нийт 50 серверийн хувилбар шинэчлэгдсэн. Шинэчлэлтийн явцад гарсан тохиргооны хүндрэлтэй холбоотойгоор үйлдвэрлэгчийн "support"-оос дэмжлэг авч ажилласан;<br>- 2025 оны 10 дугаар сарын 10-нд төлөвлөгөөний дагуу Zimbra системийн 10.1.10_GA_4735 хувилбарт "patch update" хийж, системийн хувилбарыг 10.1.7-оос 10.1.11 болгон шинэчилсэн. Энэ үеэр ноцтой эмзэг байдалд тооцогдох "SMTP mismatch login" алдааг засварлаж, тохиргооны явцад гарсан асуудлыг үйлдвэрлэгчийн туслалцаагаар шийдвэрлэсэн; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Төрийн байгууллагын цахим шуудангийн систем ашиглагч байгууллагуудаас ирсэн 98 хүсэлтэд аюулгүй байдлыг хангах, ашиглалттай холбоотой заавар мэдээлэл өгч ажилласан. | |
| 37 | **3.2.2.** | Төрийн байгууллагуудын цахим хуудасны аюулгүй байдлыг хангах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Төрийн байгууллагуудын цахим хуудаснуудыг хамгаалалтын төхөөрөмжөөр хянаж хамгаалж ажилласан байх;<br>б/ Төвд байрлах төрийн байгууллагуудын цахим хуудсанд мэдээллийн аюулгүй байдлын шалгалт хийх, зөвлөмж хүргүүлж ажилласан байх. | | 1 | • 2025 оны байдлаар нийт 14 цахим системд 35 удаагийн шалгалт хийснээс 57% нь аюулгүй байдлын хувьд "Хэвийн" гэж үнэлэгдсэн. Төвийн "sso.datacenter.gov.mn" эмзэг байдлыг 100% арилгасан. "sso.gov.mn" үүсэж болох эрсдэлийг 66.7%-иар бууруулсан.<br>• Төвийн мэдээллийн аюулгүй байдлын шалгалт хийх цахим хуудасны жагсаалтыг шинэчилж батлуулсан. 30ш цахим хуудаст эмзэг байдлын шалгалт хийж, хариуцсан мэргэжилтэнд мэдээлэл өгч, засварлах ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. | 100% |
| 38 | **3.2.3** | Төвийн систем, сүлжээний төхөөрөмжүүд рүү хандах хандалтын хяналтыг сайжруулах, хязгаарлах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Төвийн систем, төхөөрөмжийг хандалт удирдлагын системд бүрэн хамруулж системээр дамжин хандаж буй хандалтууд дээр дүн шинжилгээг хийсэн байх. | | 1 | • Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хүрээнд баталгдсан байгууллагын бүтэцтэй уялдуулан хаалганы хандах эрх болон систем бүрийн нэгдсэн хандах эрхийн матрицыг шинэчлэн боловсруулсан;<br>• Төвийн систем, сүлжээний төхөөрөмжүүд рүү хандах хандалт, хяналтыг сайжруулах, хязгаарлах ажлын хүрээнд 160ш серверийг "PAM" системд холбосон. | 100% |
| 39 | **3.2.4** | Үндсэн болон дэмжих системийн аюулгүй байдлыг сайжруулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Шинээр холбогдож буй байгууллагуудыг VPN серверт холбож хуучин VPN серверт холбогдсон байгууллагуудыг шилжүүлж сервис болон гэрээний тулгалтыг хийж нягталж ажилласан байх;<br>б/ Үндсэн болон дэмжих системийн доголдол тасалдлын хяналтыг хийх, мэдээллийн систем хөгжүүлж гэмтэл саатлын үеийн төлөвлөгөөний дагуу туршилт хийж сайжруулан ажилласан байх. | | 1 | • ХУР үндсэн системийн шинэ VPN серверт нийт 839 токен үүсгэдэж, "Active Connection"-ээр 300 хэрэглэгч холбогдсон;<br>• Шинээр холбогдсон байгууллагуудыг VPN серверт холбож, хуучин серверт ашиглаж байсан 228 байгууллагаас гэрчилгээний хугацаа дууссан 211 байгууллагын холболтыг шинэ VPN серверт шилжүүлсэн. Үлдсэн 17 байгууллагын холболтыг гэрчилгээний хугацаа дуусахад шилжүүлнэ;<br>• Танилт нэвтрэлтийн нэгдсэн "ДАН" системийн дэд бүтэц болох "Kubernetes" архитектурт микросервисүүдийн аюулгүй байдлын тохиргоо, хяналтын "Prometheus", "Grafana" системийг тохируулсан;<br>• Төрийн мэдээлэл солилцооны системд мэдээлэл нийлүүлж буй мэдээлэл хариуцагч байгууллагуудын холбогдох сервисийн доголдлын хяналтын тоон үзүүлэлтийг нэгтгэн боловсруулах системийг хөгжүүлж ашиглалтад оруулсан болно. Уг тоон үзүүлэлтээс харахад дараах байгууллагуудын сервисийн тасалдлын хувь харьцангуй өндөр байна. Үүнд:<br>- Татварын ерөнхий газар – 24.9%<br>- Сангийн яам – 77.6% | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Боловсролын мэдээллийн технологийн төв – 28.8%<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар – 37.1%<br>- Албан журмын даатгагчдын холбоо – 27.5% | |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 3. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, ДЭД БҮТЦИЙН ХЭВИЙН, ТАСРАЛТГҮЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | **Хувь** |
| **“АЛСЫН ХАРАА-2050”, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15** | | | | | | | | |
| **3** | | **Зорилт 3. Халдлагад хариу үйлдэл үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын зөвлөгөө өгөх;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **3** | **Гүйцэтгэл** | |
| 40 | **3.3.1** | Төвийн системийн найдвартай, тасралтгүй байдлыг хянах, мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах, лог бүртгэлийн нэгдсэн системээр хяналт хийх | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Лог бүртгэлийн нэгдсэн системээр хяналт хийж, дунд болон өндөр түвшний анхааруулгад дүн шинжилгээ хийж зохих хариу арга хэмжээг авсан байх; б/ Төвийн хэмжээнд хянах, мэдээлэх шаардлага бүхий системүүдийг уг системд бүрэн хамруулсан байх. | | 1 | • Лог бүртгэлийн системээс илэрсэн үр дүнг цахим шуудангаар авч дүн шинжилгээ хийж халдлагад өртсөн байж болзошгүй 13 байгууллагын системд аюулгүй байдлын анхан шатны дүн шинжилгээ хийж, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх үндэсний төв болон тухайн системийг хариуцагч байгууллагад мэдэгдсэн;<br>• Лог бүртгэлийн нэгдсэн системийн хүчин чадлын хүрээнд нийт 143ш сервер, системийн лог мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн;<br>• 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Лог бүртгэлийн нэгдсэн системийг сайжруулах шинэ систем худалдан авах санал хүргүүлсэн. | 100% |
| 41 | **3.3.2** | Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Халдлага, зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлэх зааварчилгаар боловсруулж авах арга хэмжээний төлөвлөгөөг гарган ажилласан байх. | 1 | 1 | • Төвийн кибер халдлага зөрчилд хариу үйлдэл үзүүлэх төлөвлөгөөг шинэчлэн баталж халдлага зөрчлийн илрүүлэлтийг SIEM болон бусад хяналт мониторингийн системийг ашиглан илрүүлж төлөвлөгөөний дагуу хариу арга хэмжээг авч ажилласан. Кибер халдлага, зөрчилд хариу үзүүлэх төлөвлөгөөний бэлэн байдлын туршилт, сургуулилтыг зохион байгуулж симуляци орчинд эмзэг байдал бүхий тусгайлан бэлтгэсэн “Web defacement” төрлийн халдлагад өртсөн систем дээр төлөвлөгөөний дагуу ажилласан бөгөөд халдлага үүссэн шалтгааныг зөв тодорхойлж, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн, системийн засвар болон нөхөн сэргээх үйлдлийг амжилттай хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 42 | **3.3.3** | Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлыг аудит хийлгэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хуульд заасан байгууллагаар хийлгэж гарсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу | | 1 | • “Mcloud” систем дээр ТЕГ-ийн МАБГ-аар эрсдэлийн үнэлгээ хийлгэж, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд захирлын тушаалаар дотоод ажлын хэсэг байгуулан ажилласан. Үүнд:<br>- Төрийн үүлэн тооцооллын “Mcloud” дэд бүтцэд хийгдсэн эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу эмзэг байдлуудыг арилгах, засварлах ажлыг “Фибо глобал” ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2.5, 19.2.6 | | холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн байх. | | | - Төрийн үүлэн тооцооллын "Mcloud" дэд бүтцээс төрийн нэгдсэн сүлжээнд хандах хандалтын шийдэл боловсруулж, бусад сүлжээний дэд бүтэц руу хандах хандалтын хязгаарлаж, хяналтыг сайжруулсан;<br>• Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001:2022 стандартын дагуу аудитыг олон улсын байгууллагаар хийлгэсэн. | |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ.** | | | | | | | | **Хувь** |
| ***НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ, ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 33 дугаар заалт, ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН ДҮРЭМ 4.1,4.2,4.3.,*** | | | | | | | | |
| | **1** | **Зорилт 1. Захиргаа, удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **0** | **9** | **Гүйцэтгэл** | |
| 43 | **4.1.1** | Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001 стандартыг магадлан баталгаажуулах Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.2.3 | | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн ISO:27001 стандартыг магадлан баталгаажуулахад шаардлагатай журмуудыг шинэчлэн стандартад хяналт тавьж, сургалт мэдээллийг тогтмол хийн дүрэм журмын хэрэгжилтийг хангуулж ажилласан байх. | 1 | 1 | • Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001:2013 стандартын магадлан аудит, ISO:27001:2022 стандартын шилжилтийн аудитыг олон улсын гэрчилгээжүүлэх эрх бүхий Франц улсын "Афнор" байгууллагаар 2025 оны 6 дугаар сард хийлгэж стандарт хангасан гэрчилгээг авсан. Аудитаар давуу тал 2, сайжруулах боломж 1, анхаарах хэсэг 7 гарсан бөгөөд жижиг үл тохирол болон том үл тохиролгүйгээр үнэлэгдсэн;<br>• Магадлан баталгаажуулах, хувилбар шилжих ажлын хүрээнд дараах ажлуудыг үе шаттай зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>- МАБ-ын менежментийн тогтолцооны баримтжуулалтын процесс, журам, төлөвлөгөөг шинэ стандартад нийцүүлэн шинэчилж, нотолгоо бүрдүүлэх тогтолцоог сайжруулах зорилгоор нийт 16 баримт бичиг, шинэ хяналттай уялдуулан шинээр 1 төлөвлөгөө, 6 журмыг баталсан;<br>- Нийт ажилтнуудад батлагдсан баримт бичгийн хүрээнд МАБ-ын менежментийн тогтолцооны төлөвлөгөөт сургалтыг ISO 27001 стандартын тухай, мөн МАБ-ын менежментийн тогтолцоонд мөрдөгддөг бодлого, журам, зааварчилгааны тухай мэдлэг олгох хүрээнд зохион байгуулсан;<br>- МАБ-ын менежментийн тогтолцооны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг батлуулж жилийн төлөвлөгөөний дагуу дотоод аудитыг 6 дугаар сард хийж үр дүнгийн тайланг удирдлагад танилцуулж баталгаажуулсан. | 100% |
| 44 | **4.1.2** | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг журмын дагуу удирдах дээд байгууллагад хүргүүлэх МУЗГ- | | Хүргүүлсэн баримтын тоо<br>Тоо:2<br>Чанар: а/ Төвийн үйл ажиллагааг жилээр төлөвлөж, улирал, хагас жил, жилээр тайлагнасан байх; | 0 | 2 | • Төвийн 2025-2028 оны стратеги төлөвлөлт, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, удирдлагад танилцуулж ЦХИХХЯ-д хүргүүлж 2025 оны 04 дүгээр сарын 10-нд батлуулсан;<br>• Байгууллагын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж ЦХИХХЯ-д хүргүүлсэн; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ын 2020 оны 217 дугаар тогтоол, журам | | б/ Мониторингийн тайлан, халдлагын тайлан, систем, серверийн доголдол гэмтлийн тайланг тогтмол мэдээлсэн байх. | | | • Байгууллагын хагас жилийн тайланг ЦХИХХЯ-д хүргүүлж 82.1%-тай үнэлэгдсэн;<br>• Байгууллагын 2025 оны жилийн эцсийн тайланг ЦХИХХЯ-д тайлант хугацаанд хүргүүлж ажилласан;<br>• Мониторингийн хяналтыг тогтмол хийж систем, серверийн доголдол гэмтлийг хянаж гарсан доголдлыг бүртгэн үр дүнгийн талаар удирдлагад тогтмол танилцуулан сайжруулалт хийж ажиллаж байна. | |
| 45 | **4.1.3** | Чанарын менежментийн тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Чанарын менежментийн тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулахад оролцож ажилласан байх. | 0 | 1 | • Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандарттай холбоотой баримт бичгүүдийг боловсруулж стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, "Business Systems Certification" (BCert, www.bscertification.com) Австралийн олон улсын баталгаажилтын байгууллагаас сертификатаа хүлээн авч, үйл ажиллагаагаа батламжилсан. Үүнд:<br>- Стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулсан;<br>- Стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой холбогдох ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан;<br>- Баримт бичгийн дотоод аудит, сертификатжуулалтын өмнөх дотоод аудит тус тус хийгдсэн. | 100% |
| 46 | **4.1.4** | Төвийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах | - | Журмын хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулж үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг журмын дагуу зохион байгуулж ажилласан байх. | 1 | 1 | • Төвийн үндсэн үйл ажиллагаа, төлөвлөгөө, гүйцэтгэлд хяналт шалгалт, аудит хийх, ажлын үр дүнг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай зөвлөмж өгөх төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалт зохион байгуулж тайлан дүгнэлтийг боловсруулан албажуулсан. | 100% |
| 47 | **4.1.5** | "Хүний нөөцийн бодлого"-ыг хэрэгжүүлэх, технологийн мэргэжилтний нөөцийг бэлтгэх | | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Хүний нөөцийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө гаргаж ОУ–ын мэргэшлийн сертификат эзэмшигчид олгох урамшууллыг журамд тусгасны дагуу төсөвт уялдуулан ажилласан байх;<br>б/ Төвийн нийт ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх. | | | • Хүний нөөцийн идэвхжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулж, батлуулан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Тайлант хугацаанд хүний нөөцийн хэрэгцээнд үндэслэн zangia.mn платформд 15 ажлын байр зарлаж, нийт 75 ажил горилогчийн анкетаас 21 ажилтныг шинээр ажилд авсан (28%), харин 54 ажил горилогчийг нөөцөд бүртгэн (72%) хүний нөөцийн бүрдүүлэлт, нөөцийн бүртгэлийг сайжруулсан;<br>- Япон Улсад зохион байгуулагдсан "Asia-Pacific Telecommunity Ministerial 2025" арга хэмжээнд байгууллагын нэг ажилтан оролцож, салбарын чиг хандлага, дэвшилтэт технологийн шийдлүүдтэй танилцсан бөгөөд байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлж болох мэдээлэл, туршлага хуримтлуулсан; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын “EXABEAM” байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн аюулгүй байдлын шинжээчдэд зориулсан сургалт, арга хэмжээнд холбогдох мэргэжилтэн амжилттай хамрагдсан. Хөтөлбөрийн хүрээнд орчин үеийн кибер аюул занал, зан үйлд суурилсан илрүүлэлтийн арга аргачлал, мониторингийн шийдлийн талаар мэдлэгээ өргөтгөсөн;<br>- Бүгд Найрамдах Хятад Ард Улсад зохион байгуулагдсан “Radware DDoS + WAF Training” мэргэжлийн сургалтад мэдээллийн аюулгүй байдлын ажилтан оролцож, DDoS халдлагаас хамгаалах арга техник, сүлжээний хамгаалалт, веб аппликейшн файрволлын (WAF) удирдлага, тохиргооны туршлагыг эзэмшсэн;<br>• Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, ажилтнуудын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд нийт ажилтнуудыг хамруулсан. | |
| 48 | **4.1.6** | “Чадварлаг мэргэжилтэн” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Сургалтын төлөвлөгөөний дагуу батлагдсан төсвийн хүрээнд ажлын чиг үүргийн дагуу мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулж хүний нөөцийг хөгжүүлэх дотоод арга хэмжээг зохион байгуулж ажилласан байх;<br>б/ Хүний нөөцийг сэлгэн ажиллуулах, зайнаас ажиллах, ажилтнуудын хөрвөх чадварыг нэмэгдүүлсэн байх. | 1 | 1 | • Хүний нөөцийн мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг батлуулж сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд нийт 33 сургалт, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 36 ажилтан хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн;<br>- Мэргэжлийн чиглэлийн сургалтад:<br>o Кибер болон мэдээллийн аюулгүй байдал – 38 ажилтан<br>o ICT, мэдээллийн технологи, өгөгдөл – 13 ажилтан<br>o Ур чадвар, стандарт – 66 ажилтан<br>o Нийгмийн хариуцлага, ёс зүй, жендер, авлига – 7 ажилтан хамрагдсан;<br>• 2025 онд зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, семинаруудад байгууллагын нийт ажилтны 80%-иас дээш хувь хамрагдаж, нийт ажлын чадвар 30–40%-иар өссөн;<br>• Сургалт, арга хэмжээнд тайлант хугацаанд ажилтнууд дараах үндэсний болон олон улсын мэргэшүүлэх сургалт, форум, семинарт хамрагдсан<br>- DATA+AI Conference 2025<br>- ISO/IEC 27005:2022 стандартын сургалт<br>- Security Transformation Forum 2025<br>- Indo-Pacific Cyber Programme (National Cyber Crisis Plan Workshop)<br>- Cyber Drill Asia Pacific 2025 (НИЙТ 9 ажилтан)<br>- ITACTIC-2025 стратегийн команд штабын сургуулилт<br>- MNSEC 2025 (10 ажилтан)<br>- Fortinet Accelerate25 North Asia Tour<br>- Group IB Platform Workshop | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Cyber Threat Intelligence & Risk Management<br>- MinePro 2025 Expo<br>- “Зохицуулалт 2025” олон улсын форум<br>- “Дижитал залилан ба цахим аюулгүй байдал” хэлэлцүүлэг<br>- “Эрүүл мэндийн салбарын цахимжилт ба хүний эрхийн эрсдэл” семинар<br>- “Монгол Улсын кибер аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох судалгаа”<br>- Data Analytics Forum 2025<br>- VertexMon Checkpoint сургалт<br>- Checkpoint Firewall Administrator болон CCSE гэрчилгээ<br>- Exabeam Security Intelligence Summit<br>- ICT 2025, STF Security Transformation Forum<br>- Жендерийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэлэлцүүлэг<br>- Авлигын эсрэг сургагч багшийн сургалт<br>- Oracle Cloud Seminar<br>- Сонгинохайрхан дүүргийн ОБГ-ын гамшгаас хамгаалах сургалт (41 ажилтан)<br>- Худалдан авах ажиллагааны “А3” сургалт (18 ажилтан)<br>- Нийгмийн даатгалын газрын “Ажил олгогчдын зөвлөгөөн–2025”<br>- Төрийн албаны “7:4:10” цахим сургалт<br>- Монгол бичгийн хэрэглээний сургалтууд<br>- “ДАН 2.0” танилт нэвтрэлтийн системийн сургалт<br>- Эрүүл мэндийн мэдээллийн программын шаардлага боловсруулах ажлын хэсэг<br>• Сэлгэн ажиллуулах болон зайнаас ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, дотоод зохион байгуулалтыг уялдуулсан;<br>• Уян хатан цагийн ажлын тушаалыг боловсруулан батлуулж, ажилтнуудын цагийн менежмент, хувийн зохион байгуулалт сайжирсан. | |
| 49 | **4.1.7** | Худалдан авах үйл ажиллагааг төлөвлөж, удирдах дээд байгууллагад тайлагнах | | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Хуулийн дагуу 2025 оны худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж үнэн зөв, ил тод байдлаар мэдээлсэн байх, хуулийн хугацаанд багтаан 2026 оны төвийн үйл ажиллагааны нийт төсвийг хамруулсан төлөвлөгөөг боловсруулсан байх. | 1 | 1 | • Төвийн 2024 оны худалдан авалтын тайланг tender.gov.mn цахим системээр тайлагнаж, ЦХИХХЯ-аар хянуулж, баталгаажуулснаар хуулийн хүрээнд цаг хугацаанд тайлагнаж ажилласан;<br>• Төвийн 2025 оны урсгал төсвийн худалдан авалтын төлөвлөгөөг гаргаж хуулийн хугацаанд нь ЦХИХХЯ-аар батлуулан нийт 26 худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-нд нийтэлж, 2025 оны хагас жилийн байдлаар:<br>- Үр дүн гарсан – 11,<br>- Тендер хүлээн авч байгаа төлөвтэй – 1;<br>• Шууд худалдан авалт – 6 худалдан авалт хийгдсэн байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | **4.1.8** | Төвийн санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж, жилийн тайлан балансыг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх | | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Нягтлан бодох бүртгэлийн ажиллагааг хуулийн хугацаанд холбогдох стандартуудыг баримтлан ажилласан байх;<br>б/ Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажилласан байх;<br>в/ Аудитын байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байх;<br>г/ Эд хөрөнгийн тооллогыг хагас жил тутамд хийсэн байх. | 1 | 1 | • Үйл ажиллагааны орлого 7,631,515,843 мянган төгрөг төвлөрсөн үүнээс:<br>- "Зогсуур түрээс" 201,088,133 мянган төгрөг;<br>- "МИХХ" төлбөр 73,000,000 мянган төгрөг;<br>- "ХУР" системийн сервис ашигласан үйлчилгээний төлбөр 7,357,427,710 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Сар бүрийн 20 гэхэд "ХУР" системийн сервис ашигласны төлбөр бүрэн төлөгддөг болсон;<br>• Батлагдсан төсвийн хүрээнд сар улирлын төсвийн хуваарь болон 2025 оны худалдан авах төлөвлөгөөний дагуу 539 удаагийн гүйлгээгээр 6,186,756.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг бүртгэн Сангийн яамны төрийн сангийн газарт хянуулан төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна;<br>• 2024 оны Төсвийн гүйцэтгэлийн мэдээг бэлтгэн, Төрийн сангийн цахим хуулгатай тулган баталгаажуулан, Сангийн яам, ЦХИХХЯ-д хуулийн хугацаанд хүргүүлж баталгаажуулсан;<br>• Шилэн дансны хуулийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн хуулийн хугацаанд байгууллагын санхүүгийн мэдээг www.shilendans.gov.mn веб хуудсанд байршуулсан;<br>• 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаанд нь бэлтгэн баталгаажуулан Үндэсний аудитын газар, "Эн Ай Ти Эс баланс Аудит" ХХК тус тус хүргүүлж, тайлангийн аудитыг хийлгүүлж, "Өөрчлөлтгүй" дүгнэлтийг авсан;<br>• 2025 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг хийж удирдлагад танилцуулж албажуулсан;<br>• Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 23 тоот тогтоолоор 57 нэр төрлийн 391ш 3,246,536.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталж устгасан. Мөн 2024 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтээс шийдэгдсэн 2 автомашиныг дансанд орлого болгон бүртгэсэн;<br>• 2025 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг хийж удирдлагад танилцуулж, Хагас жилийн тооллогоор Биет бус хөрөнгө лицензийг тоолж нэг жилийн хугацаатай лицензийн жагсаалтыг үйлдэн өмч хамгаалах комиссын хуралдаанд хэлэлцүүлэн Төрийн өмчийн хороонд албан бичгээр хүргүүлэн ажилласан;<br>• 2025 оны засварын аудитаар ажиллах "ЦЭБЭ консалтинг аудит" ХХК-тай гэрээ байгуулан холбогдох баримтыг цахимаар хүргүүлсэн. | 100% |
| 51 | **4.1.9** | Дата төвийн цаашдын үйл ажиллагаа, | | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Хүний нөөцийн | 1 | 1 | • ҮБХИС, АБДС, ШУТИС-ийн төгсөх курсийн оюутнуудад зориулсан үйлдвэрийн дадлагын хөтөлбөрийг зохион байгуулж, нийт 3 их, дээд сургуулийн 16 оюутан дадлагажсан; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | технологийн дэвшлийг хангах зорилгоор мэргэжлийн, өндөр ур чадвартай хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх. | | хөгжлийн стратегийн дагуу мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах;<br>б/ Хамтын ажиллагаанд суурилсан боловсон хүчин бэлтгэх<br>в/Тасралтгүй хөгжлийн тогтолцоо бүрдүүлж гадаад мэргэжилтэн, туршлага солилцоог нэвтрүүлэх | | | • Ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор 2 ажилтантай тогтвортой ажиллах сургалтын гэрээ байгуулж, мэргэшлийн түвшин, ур чадварыг шат дараатай нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн;<br>• Үндэсний аудитын газрын хүсэлтийн дагуу хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд нэг ажилтныг дагалдуулан сургах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлснээр байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, туршлага солилцооны тогтолцоог бэхжүүлсэн;<br>• МУЗГ-ын 2025 оны 109 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд сар шинийн амралтын 3 хоногийг нөхөн ажиллах хуваарийг боловсруулж, ажилтнуудад хүргүүлэн зохион байгуулсан;<br>• Хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх, технологийн чиглэлээр мэргэшүүлэх зорилгоор байгууллагын жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Төсөвтэй уялдуулан ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, олон улсын сертификаттай сургалтад хамруулах, сэлгэн ажиллуулах болон хөрвөх чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр дата төвийн технологийн чадавх бодитойгоор нэмэгдсэн. | |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ.** | | | | | | | | **Хувь** |
| ***НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ, ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 33 дүгээр заалт, ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН ДҮРЭМ 4.1,4.2,4.3.*** | | | | | | | | |
| **2** | | **Зорилт 2. Хамтын ажиллагаа хөгжүүлэх;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **4** | **Гүйцэтгэл** | |
| 52 | **4.2.1** | “Гадаад хамтын ажиллагаа, гадаад арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулж хэрэгжүүлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Салбарын олон нийтийг хамарсан арга хэмжээ, мэдээ, мэдээлэлтэй уялдуулан байгууллагаас хийгдсэн ажлуудыг сурталчилгааны олон талт сувгуудыг ашиглаж нийтэд тогтмол мэдээлж ажилласан байх;<br>б/ Байгууллагын үйл ажиллагааг таниулж нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байх. | | | • Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын үйл ажиллагааг таниулах ПР төлөвлөгөө гаргаж ажилласан;<br>• Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д “Шилэн индекс”-ийн 1 дүгээр улирлын тайланг хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг Нээлттэй мэдээллийн системд байршуулан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. 1-р улирлын байдлаар шилэн индекс 92,2% үзүүлэлттэй үнэлэгдсэн;<br>• Салбарын бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, олон нийтийг хамарсан мэдээ, мэдээллийг өөрийн байгууллагын мэдээллийн хэрэгслээр тогтмол нийтэлсэн;<br>• Удирдах дээд байгууллагаас хэрэгжүүлсэн болон чиглэл өгсөн арга хэмжээг зохион байгуулж дэмжиж ажилласан;<br>• Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын байгууллагуудын хооронд зохион байгуулагдсан “HYPER CUP-2025”, “DIGITAL CUP 2025”, “ICT”-2025-ийн хүрээнд арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг амжилттай хийж гүйцэтгэсэн; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Үндэсний аудитын газрын зүгээс гаргасан хүний нөөцийг сургах, дадлагажуулах тал дээр дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах хүрээнд дагалдуулан ажиллуулах хүсэлтийн дагуу төлөвлөгөө Систем админ 1 сарын хугацаатай ажилласан;<br>• Тархмал бүтэцтэй танилтын системийг Монгол улсад нэвтрүүлэх судалгааны төслийн ажлын хэсэгт орж дэмжлэг үзүүлэн ажилласан;<br>• “Чимэгэ системс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан дата төвд хиймэл оюун ухаанд суурилсан системийг ажиллуулах өндөр хүчин чадал бүхий серверийг байршуулах гэрээ байгуулсан;<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн 09-00/09 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд ЦХХХЯ, МХС, И-Монгол академи, Үндэсний Дата төв, КХЗТНТ-ийн бүрэлдэхүүнтэй “Коди” ХХК-ний хөгжүүлсэн www.enaadam.mn цахим сайт, тасалбар цахимаар борлуулах систем, өгөгдлийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан. | |
| 53 | **4.2.2** | Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд Төрийн клауд системийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт, зохион байгуулах | | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд Төрийн клауд системийн талаарх мэдлэг мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулсан байх;<br>б/ Салбарын экспо, ойн арга хэмжээнд оролцож бусад холбогдох зохион байгуулалтын үйл ажиллагаанд хамтран ажилласан байх. | | | • Төрийн клауд систем болох MCloud системд нийт 107 байгууллага гэрээ байгуулан, 114 байгууллагын 469 систем ажиллаж байна. MCloud системтэй холбоотой 425 хүсэлтийг шийдвэрлэсэн. Төрийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтнуудад тухай бүр зааварчилгаа өгч ажилласан;<br>• “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-аас ирүүлсэн өндөр үзүүлэлт бүхий зохиомол серверүүд авах албан хүсэлтийн дагуу холбогдох ажилтнуудтай цахим хурал зохион байгуулж төрийн клауд системд үйлчилгээг олгож заавар зөвлөгөө сургалт орсон;<br>• Төвийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах сурталчлах ажлын хүрээнд байгууллагын фейсбүүк пэйж хуудсанд нийтлэгдэх хэрэглэгчийн үйлчилгээтэй холбоотой хамгийн түгээмэл ирдэг асуулт, тэдгээрийн хариултыг багтаасан мэдээллүүдийг тогтмол илгээж мэдээ мэдээллээр хангаж ажилласан;<br>• Удирдах дээд байгууллагаас хэрэгжүүлсэн болон чиглэл өгсөн арга хэмжээг зохион байгуулж дэмжиж ажилласан. | 100% |
| 54 | **4.2.3** | Удирдах дээд байгууллагуудаас байгуулагдаж буй ажлын хэсгүүдэд хамрагдах хэлбэрээр хамтран ажиллах | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: а/ Ажлын хэсгийн хурлуудад оролцож байгууллагын санал, дүгнэлтийг хүргүүлж ажилласан байх. | | | • Тайлант хугацаанд удирдах дээд байгууллагуудаас байгуулагдсан ажлын хэсгүүдэд хамтран ажиллаж, байгууллагын санал, дүгнэлт, техникийн зөвлөмжийг тогтмол хүргүүлэн дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>- “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг болон “Хэрэглэгч, мэдээлэл, харилцаа холбоо” хэлэлцүүлэгт хэлэлцүүлэгт орж ажилласан;<br>- БОАЖЯ-аас зохион байгуулсан салбарын уулзалтад оролцсон; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - 21 аймгийн бүх сумдыг Төрийн цахим үйлчилгээний КИОСК машинтай болгох ажлын хүрээнд, орон нутгийн киоск машины хуваарилалт, гардуулах ажиллагааны зохион байгуулалтад оролцож, техникийн бэлэн байдлыг ханган ажилласан;<br>- ЦХИХХЯ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу, “Гэрэгэ Системс” ХХК-аас тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг магадлан шалгах ажлын хэсэгт ажилласан;<br>- “Шинэ Зуунмод Дата төв” болон “Үндэсний цахим шуудан” төслүүдийн саналыг боловсруулж ЦХИХХЯ-д хүргүүлсэн.<br>- ЦХИХХЯ-ны сүлжээний дэд бүтцийг шинэчлэх, сайжруулах ажлын хэсэгт орж ажиллаж хэрэгжүүлэх шаардлагатай техникийн зөвлөмжийг боловсруулж ажлын хэсэгт танилцуулсан;<br>- Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ITU)-ийн “CyberDrill 2025” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт оролцож, кибер аюулгүй байдлын бэлэн байдлыг хангах чиглэлээр хамтран ажилласан;<br>- “Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар”-аас байгуулсан "Doing Business" тайлангийн шалгуур үзүүлэлтийг сайжруулах асуудлаар санал, дүнг гарган боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралд оролцсон;<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт ЦХИХХЯ болон ХХААХҮЯ-ны төлөөлөлтэй хамтран оролцсон;<br>- Нийт үйлчилгээний гэрээний бүртгэлийг сайжруулах, төлбөр тооцоог хянаж баталгаажуулах, төвийн серверийн өрөөнд байрлах тоног төхөөрөмж, зогсуурын ашиглалт болон нөөцийн төлөв байдлыг үнэлэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, шинжилгээ, санал зөвлөмжийг гарган ажилласан. | |
| 55 | **4.2.4** | Төрийн байгууллагуудад үйл ажиллагаа, үйлчилгээг цахимжуулахад дэмжлэг үзүүлэх | | Хэрэгжилтээр<br>Тоо:2<br>Чанар: а/ Тухайн байгууллагын үйл ажиллагааг хөнгөвчилж, зардлыг бууруулахад чиглэгдсэн байх;<br>б/ Байгууллагаас үзүүлэх үйлчилгээнд тавигдах техникийн тодорхойлолт, нийтлэг шаардлагыг боловсруулсан байх. | | | • Төрийн байгууллагууд, яам, салбарын хэмжээнд ашиглах боломжтой шуурхай хурлын (e-meeting.gov.mn) системийг хөгжүүлж ЦХИХХЯ-ны шуурхай хурлын үйл ажиллагаанд ашиглаж байна. Түүнчлэн төрийн тусгай хамгаалалттай газруудын нэвтрэлт бүртгэлийн “Epass” мөн Монгол Улсын Засгийн Газрын “mongolia.gov.mn” системийн ашиглалт, үйл ажиллагааны тасралтгүй найдвартай байдлыг ханган ажилласан;<br>• Цахим санал асуулгын хуудсыг хөгжүүлж, (admin.gov.mn) цахим хуудсанд нэвтрүүлсэн. Уг хөгжүүлэлтээр санал асуулгыг дэлгэцэд харуулах, автоматаар гүйлгэх, болон асуулгыг зөвшөөрөх зэрэг функцуудыг нэмж ЗГ-ын бүсийн өргөтгөсөн хуралдаанд Булган, Дорноговь аймгуудад ашигласан; | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • ЦХИХХЯ-ны сүлжээний дэд сүлжээг сайжруулах ажлын хэсгийн хүрээнд холбогдох зөвлөмж мэдээллийг өгч дэмжлэг үзүүлэн ажилласан;<br>• Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон БОУАӨЯ-ны сүлжээ дэд бүтцийн аюулгүй байдлыг сайжруулах зөвлөмж боловсруулан өгч хамтран ажилласан. | |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ.** | | | | | | | | **Хувь** |
| **АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| **3** | | **Зорилт 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэмжиж ажиллах** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **1** | **Гүйцэтгэл** | |
| 56 | **4.3.1** | Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Удирдах дээд байгууллагаас зохион байгуулсан авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажилласан байх. | 0 | 1 | • Төвийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 14-д батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд:<br>- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигын эсрэг сургалт, сурталчилгааг зохион байгуулах сургагч багш бэлтгэх хөтөлбөрт хөтөлбөрт Захиргаа, удирдлагын хуульч хамрагдсан;<br>- Нийт албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх сургалтыг 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулсан;<br>- Мэдүүлэг гаргах үүрэг бүхий ажилтнуудад мэдүүлэг гаргахтай холбоотой зөвлөмж, сургалт мэдээллийг 2025 оны 1 дүгээр сард зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд тухай бүр мэдээ мэдээллээр хангаж ажилласан;<br>- Авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан постер мэдээллийг байгууллагын сошиал хуудас болон веб сайтаар дамжуулсан;<br>- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 9 албан тушаалтныг 2025 оны 2 дугаар сарын 15-ний өдрийн дотор буюу хуулийн хугацаанд Хөрөнгө орлогын мэдүүлгийг цахим системд мэдүүлж, баталгаажуулан холбогдох тайланг ЦХИХХЯ-д хүргүүлсэн;<br>- Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгаж оруулан гэрээг байгуулсан. | 100% |
| 57 | **4.3.2** | Иргэний нийгмийн байгууллагын эрх | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1 | 0 | 1 | • “Удирдах дээд байгууллагаас Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх | | Чанар: а/ Удирдах дээд байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагааны ажлын хэсэгт орж ажилласан байх. | | | нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулагдаагүй. Удирдах дээд байгууллагаас авлигын эсрэг хамтын ажиллагаатай холбоотой олон нийтийг уриалсан сошиал постер болон бусад мэдээ мэдээллийг холбогдох олон нийтийн сувгуудаар түгээж ажилласан. | |
| 58 | **4.3.3** | Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Удирдах дээд байгууллагаас зохион байгуулсан хөтөлбөр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан байх. | 0 | 1 | • "Удирдах дээд байгууллагаас Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр арга хэмжээ зохион байгуулагдаагүй. | 100% |
| 59 | **4.3.4** | "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Журмын хэрэгжилтийг хангахтай холбоотой удирдах дээд байгууллагатай хамтран ажилласан байх. | 0 | 1 | • Байгууллагын албан хаагчдын хяналт хэрэгжүүлэгчдийг чадавхжуулах хүрээнд "Төрийн байгууллагын ил тод байдал", "Мэдээлэл авах эрх", "Хяналтын тайлан боловсруулах аргачлал", "Авлигын эрсдэлийн үнэлгээ хийх арга" сургалтуудыг зохион байгуулсан. | 100% |
| 60 | **4.3.5** | Засгийн газар, яамд, агентлагаас батлах дүрэм, журам, заавар, стандартын төслийг боловсруулахад иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, тэднээс санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийг хөгжүүлэхэд шаардлагатай зохих | 0 | 1 | • Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.7-д заасны дагуу хууль, дүрэм, журам, заавар, стандартын төслийг боловсруулахад иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийн хөгжүүлэлтийг дэмжин ажилласан;<br>• Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг хэсэг бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн legalinfo.mn систем дээр ажилладаг. Тус систем хэвийн, найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулагчдын оролцоог хангах, тэднээс санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийг бий болгох | | дэмжлэгийг үзүүлж ажилласан байх. | | | байгууллагад Зохиомол серверийн үйлчилгээ болон Танилт, нэвтрэлтийн нэгдсэн "ДАН" системийн үйлчилгээг тогтвортой үзүүлж, шаардлагатай техникийн дэмжлэгийг үзүүлэн ажилласан. | |
| 61 | **4.3.6** | Засгийн газар, яам, агентлагаас батлах дүрэм, журам, заавар, стандартын төслийг боловсруулахад иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, тэднээс санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийг ажиллуулах журмыг боловсруулж, батлуулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын оролцоог хангах, тэднээс санал авах, тусгах, хариу өгөх үйл ажиллагааг нэгтгэсэн цахим системийг ажиллуулах тус журмын төсөлд зохих саналыг өгсөн байх. | 0 | 1 | • Цахим системийг ажиллуулах журмын төсөлд санал ирүүлэх тухай албан бичиг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас тус төвд ирээгүй тул санал боловсруулаагүй. | 100% |
| 62 | **4.3.7** | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах | | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Удирдах дээд байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байх. | 0 | 1 | • Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан постер мэдээллийг байгууллагын сошиал хуудас болон веб сайтаар дамжуулсан;<br>• Байгууллагын хэмжээнд нийт албан хаагчдад зориулсан 3 сургалт, мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан хаагчдад зориулсан 1 сургалт, нийт албан хаагчдыг хамруулсан хэлэлцүүлэг, "Авлигын эсрэг сайн дурын идэвхтэн" хөтөлбөр хэрэгжүүлэн ажилласан. | 100% |
| 63 | **4.3.8** | Нийтийн сонголын тухай хуульд заасан сонголд иргэн, | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Нийтийн сонголын | 0 | 1 | • Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигын эсрэг сургалтаар дамжуулан албан хаагчдад нийтийн сонгол хэрхэн хийгддэг, оролцооны талаарх сургалт мэдээллийг 2025 оны 10 дугаар сард зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх | | үйл ажиллагаанд оролцож дэмжиж ажилласан байх. | | | | |
| 64 | **4.3.9** | Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг цахим системд байршуулсан байх. | 0 | 1 | • Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан олон нийтэд нээлттэй ил тод байлгахаар заасан мэдээллийг байгууллагын сайт болон шилэн дансны цахим систем, нээлттэй өгөгдлийн opendata цахим систем тус тус байршуулж ажилласан. | 100% |
| 65 | **4.3.10** | Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах | - | Хэрэгжилтээр<br>Тоо:1<br>Чанар: а/ Олон нийтэд сурталчлах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байх. | 0 | 1 | • Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан авлигын эсрэг сургалт, сурталчилгааг байгууллагын албан хаагчдад сургалт байдлаар танилцуулж мэдээлэл хүргэж ажилласан. | 100% |
| **ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН СТРАТЕГИ 4. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ДЭД БҮТЦЭД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛНЭ.** | | | | | | | | **Хувь** |
| **“АЛСЫН ХАРАА-2050”, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 7.5.8, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 7.2.2.1, АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.15** | | | | | | | | |
| **4** | | **Зорилт 4. Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хууль эрх зүйн орчныг шинэчлэх, таатай нөхцөл бүрдүүлэхэд өөрийн байгууллагын зүгээс шаардлагатай судалгаа хийж, санал боловсруулах;** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **1** | **1** | **Гүйцэтгэл** | |
| 66 | **4.4.1** | Салбарын хэмжээнд боловсруулагдаж буй хууль, эрх зүй, бодлогын баримт бичигт санал өгөх | - | Хэрэгжилтээр<br>Тоо: 1<br>Чанар: б/ Салбарын хэмжээнд боловсруулагдах хууль, эрх зүйн баримт бичгийн төслүүдэд санал өгсөн байх. | 1 | 1 | • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийг боловсронгуй болгох, санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс 2024-11-22-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбоо болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбаруудын төлөөлөлтэй хийх цуврал уулзалтад оролцож ажилласан. | 100% |
| | | | | | | | | **99,3%** |